МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРОО
In partnership with Canada
The Asia Foundation
Improving Lives, Expanding Opportunities
KORE GLOBAL
IRIM INDEPENDENT RESEARCH INSTITUTE OF MONGOLIA



# МОНГОЛЫН БИЧИЛ БОЛОН ЖИЖИГ БИЗНЕС ЭРХЛЭГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДЭД КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

## ЭЦСИЙН ТАЙЛАН

Улаанбаатар хот, 2021 он

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРОО

In partnership with Canada

The Asia Foundation
Improving Lives, Expanding Opportunities

KORE GLOBAL

IRIM INDEPENDENT RESEARCH INSTITUTE OF MONGOLIA



# МОНГОЛЫН БИЧИЛ БОЛОН ЖИЖИГ БИЗНЕС ЭРХЛЭГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДЭД КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

## ЭЦСИЙН ТАЙЛАН

Улаанбаатар хот
2021 он

# АГУУЛГА

Талархал ........ 6
Тайлангийн хураангуй ........ 7
**1. Хандлага болон арга зүй ........ 10**
**2. Суурь хүчин зүйлсийн үнэлгээ ........ 12**
**2.1 Төрийн болон өрхийн хүчин зүйлийн нөхцөл байдал ........ 12**
2.1.1 Төрийн хүчин зүйл ........ 12
2.1.1.1 Төрийн зохицуулалтын арга хэмжээнүүд ........ 13
2.1.1.2 КОВИД-19-ын үеийг даван туулахад төрийн зүгээс үзүүлсэн эерэг дэмжлэг ........ 14
2.1.1.3 КОВИД-19-ын үеийг даван туулахад төрийн зүгээс учруулсан хүндрэл бэрхшээл ........ 15
2.1.2 Өрхийн нөхцөл байдал ба бизнесийн дэмжлэг ........ 23
2.1.2.1 КОВИД-19-ын үеийг даван туулахад бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлсэн өрхийн хүчин зүйлс ... 24
2.1.2.2 КОВИД-19-ыг даван туулахад бизнес эрхлэгчдийг хязгаарласан өрхийн хүчин зүйлс ...... 24
**3. Эдийн засаг болон нийгмийн капиталын үнэлгээ ........ 30**
**3.1 Эдийн засгийн капитал ........ 31**
3.1.1 КОВИД-19-ын өмнөх капитал ........ 31
3.1.2 КОВИД-19-ын үеийн аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө ба хөрөнгийн менежмент ........ 35
3.2 Нийгмийн капитал ........ 38
**4. Чадамжийн үнэлгээ ........ 43**
**4.1 Эрүүл, аюулгүй байдал ........ 43**
**4.2 Бизнест үзүүлж буй мэдээ, мэдээллийн үр нөлөө ........ 47**
**4.3 Оролцоо ба бизнес эрхлэлт ........ 49**
**5. Дүгнэлт ........ 52**
**6. Санал ........ 57**
**Хавсралт 1. Арга зүй болон гол бүрэлдэхүүн хэсгүүд ........ 59**
**Үнэлгээний зорилго ........ 59**
**Агуулгын хүрээ ........ 59**
**Үнэлгээний бүрэлдэхүүн хэсгүүд ........ 60**
Бүрэлдэхүүн 1: Тоон судалгаа ........ 60
Бүрэлдэхүүн 2: Чанарын судалгаа ........ 62
**Хавсралт 2. Асуумж ........ 64**
**Хавсралт 3. Чиглүүлэгтэй ярилцлага/Тэмдэглэл хөтлөх удирдамж ........ 77**
**Хавсралт 4. Кейс судлах ........ 79**

**Диаграмм, зураг болон хүснэгтийн жагсаалт**

Диаграмм 1: Агуулгын хүрээнд суурилсан судалгаа ........ 8
Диаграмм 2: Судалгаанаас урган гарсан агуулгын хүчин зүйлс ........ 12
Диаграмм 3: Капиталын үнэлгээний үр дүнгүүд ........ 30
Диаграмм 4: Чадамжийн үнэлгээний үр дүнгүүд ........ 43
Диаграмм 5: Монгол дахь Азийн Сангийн судалгааны хамрах хүрээ ........ 59

Зураг 1: Монгол дахь Азийн Сангийн судалгааны хамрах хүрээ ........ 11
Зураг 2: Үнэлгээний бүрэлдэхүүн хэсэг ........ 11
Зураг 3: КОВИД-19 цар тахлын үеийн бизнесийн үйл ажиллагаа ........ 15
Зураг 4: Эмэгтэй бизнес эрхлэгчдэд КОВИД-19 цар тахлын эсрэг авсан бодлогын түвшний арга хэмжээний нөлөөлөл ........ 16
Зураг 5: Эмэгтэйчүүдийн өмчит бизнест КОВИД-19-ын үзүүлсэн сөрөг нөлөө болон бэрхшээлүүд ........ 17
Зураг 6: Эмэгтэй эзэнтэй бизнесийн үйл ажиллагааны нөхцөл байдал, байршлаар (судалгаа хийсэн үеийн байдлаар) ........ 19

Зураг 7: Бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөх эрсдэлийн түвшин, бизнесийн салбараар ... 20
Зураг 8: Эмэгтэй эзэдтэй бизнесийн нөхцөл байдал, салбараар ... 20
Зураг 9: Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин ... 23
Зураг 10: Хуучин хамтрагчаасаа санхүүгийн дэмжлэг авдаг байдал ... 23
Зураг 11: Гэрлэлтийн байдал ... 23
Зураг 12: Арван долоогоос доош насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийн гүйцэтгэдэг үүрэг ... 25
Зураг 13: Судалгаа авах үе дэх бизнесийн нөхцөл байдал, гэрлэлтийн байдлаар ... 27
Зураг 14: Бизнесийн өмчлөлийн хэлбэр ... 31
Зураг 15: Бизнесээ тогтвортой явуулахад авах чухал арга хэмжээ ... 32
Зураг 16: Зээл авсан байдал ... 33
Зураг 17: Зээл авахад тулгарсан бэрхшээл ... 34
Зураг 18: Барьцаа хөрөнгөтэй холбоотой бэрхшээл, гэрлэлтийн байдлаар ... 35
Зураг 19: Барьцаа хөрөнгөтэй холбоотой бэрхшээл, хөгжлийн бэрхшээлтэй эсэхээр ... 35
Зураг 20: Барьцаа хөрөнгөтэй холбоотой бэрхшээл, салбараар ... 35
Зураг 21: Барьцаа хөрөнгөтэй холбоотой бэрхшээл, байршлаар ... 35
Зураг 22: Оролцогчдын гишүүнчлэлийн байдал ... 38
Зураг 23: Гишүүнчлэлтэй байгууллагын тоо ... 38
Зураг 24: Бизнес эрхлэхэд хүйсээс хамааран тулгарч буй бэрхшээл ... 40
Зураг 25: Танилын холбоо, хүрээллээ өргөтгөх боломж хязгаарлагдмал, бизнесийн эзэмшлийн хэлбэр .. 41
Зураг 26: Танилын холбоо, хүрээллээ өргөтгөх боломж хязгаарлагдмал, гэр бүлийнхээ хэн нэгнийг асардаг эсэх ... 41
Зураг 27: Хэн нь илүү их орлого олдог вэ? ... 44
Зураг 28: Бие дааж шийдвэр гаргах боломж ... 44
Зураг 29: Гэр бүлийн дэмжлэг ... 44
Зураг 30: Бизнесийн өнөөгийн байдал, хөгжлийн бэрхшээлээр ... 44
Зураг 31: Гэр бүлийн гишүүдийн зүгээс заналхийлсэн, дарамтлах сөрөг хандлага, үйлдэлтэй тулгарч байсан байдал ... 45
Зураг 32: Ганцаараа (эмэгтэй хүний хувьд) олон нийтийн газар жижиг бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд амар тайван, аюулгүй байх боломж, байршлаар ... 46
Зураг 33: Ганцаараа (эмэгтэй хүний хувьд) олон нийтийн газар жижиг бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд амар тайван, аюулгүй байх боломж, хөгжлийн бэрхшээлтэй байдлаар ... 46
Зураг 34: Бизнесийн дэмжлэг зөвлөгөө авсан байдал ... 47
Зураг 35: Салбарын хөгжил, чиг хандлагатай холбоотой мэдээлэл авдаг байдал ... 47
Зураг 36: Оролцох, дуу хоолойгоо илэрхийлэх боломж ... 49
Зураг 37: Оролцоо, нөлөө ... 49
Зураг 38: Санхүүгийн бус дэмжлэг авсан байдал, гишүүнчлэлээр ... 54
Зураг 39: Санхүүгийн бус дэмжлэг авсан байдал, гэрлэлтийн байдлаар ... 54
Зураг 40: Үнэлгээний бүрэлдэхүүн хэсгүүд ... 60
Зураг 41: Ажилтны тоо ... 61
Зураг 42: Жилийн дундаж орлогын хэмжээ ... 61
Зураг 43: Бизнесийн үйл ажиллагааны салбар, n=75 ... 63
Зураг 44: Оролцогчдын бизнес эрхэлж буй байршил, n=75 ... 63

Хүснэгт 1: Ажилтнуудын тооны өөрчлөлт ... 18
Хүснэгт 2: Эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүгийн эх үүсвэр; бизнесээ эхлүүлэхдээ болон үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад (хувиар) ... 32
Хүснэгт 3: Эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүгийн нөөц (хувиар) ... 37
Хүснэгт 4: Нийтлэг гишүүнчлэлтэй байгууллагууд ... 39
Хүснэгт 5: ЖДҮ-д зориулсан санхүүгийн бус дэмжлэг ( хувиар) ... 39
Хүснэгт 6: ЖДҮ-д зориулсан санхүүгийн бус дэмжлэг (хувиар) ... 47
Хүснэгт 7: Давуу болон сайжруулах шаардлагатай ур чадвар ... 48
Хүснэгт 8: БЖДҮ-д үзүүлж байсан санхүүгийн бус дэмжлэг, хувиар ... 50
Хүснэгт 9: Бизнесийн төрөл ба байршил ... 61
Хүснэгт 10: Мэдээлэл цуглуулах арга ба оролцогчдын төрөл ... 62
Хүснэгт 11: Түүврийн хэмжээ, зорилтот байршлаар ... 63

# ТАЛАРХАЛ

Азийн сангийн Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх төсөл (ЭЭЧБ) болон Хараат бус Судалгааны Хүрээлэн (IRIM) нь, Канадын Гадаад Хэргийн Яамны дэмжлэгтэйгээр “Монголын жижиг болон бичил (албан бус) бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд КОВИД-19 цар тахлын үзүүлж буй нөлөөллийн үнэлгээ” сэдэвт тус судалгааг 2020 оны 10 дугаар сараас 2021 оны 7 дугаар сарын хооронд явуулав.

IRIM Хараат бус судалгааны хүрээлэнгийн зүгээс энэхүү судалгааг амжилттай хийхэд хувь нэмэр оруулсан бүх хүмүүст чин сэтгэлийн талархал илэрхийлж байна. Тухайлбал, судалгааны ажилд шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж, судалгааны тайланг боловсруулахад дэмжлэг үзүүлж, удирдан чиглүүлж ажилласан Азийн сан болон KORE Global-ын баг хамт олонд талархлаа илэрхийлье.

Монгол дахь Азийн сангийн хамт олонд, ялангуяа Эдийн засгийн хөтөлбөрүүд хариуцсан захирал Тришиа Төрболд болон Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх төслийн Ахлах мэргэжилтэн Гантуяагийн Цолмон, KORE Global Consulting-ийн Үүсгэн байгуулагч, захирал Ребекка Калдер болон Техникийн мэргэжилтэн Федерика Бузиелло нарт тусгайлан талархсанаа илэрхийлж байна.

Түүнчлэн, энэхүү тайланд орсон гэрэл зургийг авсан Дэлгэржаргалын Давааням, ерөнхий дизайныг гүйцэтгэсэн Жамбалын Батбаатар нарт талархал илэрхийлье.

Мөн энэхүү судалгааг амжилттай гүйцэтгэхэд Монгол Улсын Засгийн газрын Жендерийн үндэсний хорооны зүгээс чухал дэмжлэг үзүүлж хамтран ажилласныг цохон дурдаж байна.

# ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Монгол Улсад ойролцоогоор 80 мянган аж ахуйн нэгж улсын бүртгэлтэйгээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 86 хувь нь жижиг дунд үйлдвэрлэл (ЖДҮ) юм. ЖДҮ нь 800 мянган хүн буюу Монгол Улсын нийт ажиллах хүчний 57 хувийг ажлын байраар хангадаг. ЖДҮ-ийн тухай хуульд жилийн 300 саяас 1 тэрбум хүртэлх төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй, 10-50 хүнийг ажлын байраар хангадаг бизнесийг "жижиг бизнес", харин 300 сая хүртэлх эргэлтийн хөрөнгөтэй 10 хүртэлх хүнийг ажлын байраар хангадаг бол "бичил бизнес" гэж тодорхойлдог. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй ЖДҮ-ийн 59 хувь буюу дийлэнх нь жилийн 50 хүртэлх сая төгрөгийн[1] эргэлтийн хөрөнгөтэй үйл ажиллагаа явуулдаг бичил бизнес эрхлэгчид байна. Фридрих Эберт Сангийн явуулсан судалгаагаар, албан бус салбарт ажиллагчдын 69.1 хувь нь эмэгтэйчүүд[2] байна. Цаашилбал, албан бус салбарт ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн дийлэнх буюу 79 хувь нь худалдаа үйлчилгээ болон дахин боловсруулалтын салбарт[3] ажиллаж байна.

Харамсалтай нь "эмэгтэй эзэнтэй бизнес" эсвэл "албан бус бизнес" гэдэг тодорхойлолт хуульд байдаггүй бөгөөд Монгол дахь албан болон албан бус бизнес бүртгэлийн мэдээллийн санд хүйсээр ангилсан нарийвчилсан мэдээлэл хомс байна. Үүгээр зогсохгүй, КОВИД-19 цар тахлын албан бус бизнес эрхлэгчдэд үзүүлж буй нөлөөнд жендерийн дүн шинжилгээ хийгдээгүй байна.

Тус үнэлгээг жижиг болон бичил бизнес эрхлэгч, тэр дундаа албан бус салбарт ажиллаж буй эмэгтэйчүүдэд КОВИД-19 цар тахал хэрхэн нөлөөлсөн талаар ойлгож, дата мэдээлэл цуглуулах зорилгоор, Канадын Гадаад Хэргийн Яамны дэмжлэгтэйгээр Азийн сангийн Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх төслийн зүгээс удирдан явуулсан болно. Цар тахлын сөрөг үр дагавар болон Монгол дахь жижиг болон бичил (албан бус) бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд учруулж буй хүндрэл бэрхшээлийг бууруулах арга шийдэл, анхаарах асуудлуудыг олж тодорхойлоход судалгааны хүрээгд цуглуулсан мэдээлэл нэн шаардлагатай юм.

"КОВИД-19 цар тахал нь жижиг болон бичил (албан бус) бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд хэрхэн нөлөөлсөн бэ?" гэсэн ерөнхий асуултын хүрээнд судалгааны ажлыг гүйцэтгэсэн болно. Судалгааны үндсэн зорилго нь жижиг болон бичил (албан бус) бизнес эрхэлж буй эмэгтэй болон эрэгтэй бизнес эрхлэгчдэд КОВИД-19 цар тахлын үзүүлсэн нөлөөг харьцуулан үнэлэх; бизнесийн салбарын онцлог, орчин, нөхцөл байдлын хүчин зүйлсээс хамааран эдгээр бүлгүүд хэрхэн КОВИД-19 цар тахлыг ялгаатай байдлаар даван туулж байгааг илрүүлж үнэлэхэд оршсон. Энэхүү үнэлгээнд 5С буюу нөхцөл байдал, капитал, чадамж, КОВИД-19 болон орон нутаг зэрэг үнэлгээний өгөгдлийг (Бүлэг 1) боловсруулж, албан бус бизнес эрхэлдэг эмэгтэй, эрэгтэй бизнес эрхлэгчдийн хот болон орон нутаг дахь нөхцөл байдлыг нь тодорхойлохыг зорьсон. Судалгааны зорилго, хүрээтэй уялдуулан 3С буюу нөхцөл байдал, капитал болон чадамж гэсэн хэсгийг голлон анхаарч, илүү нарийвчлан (Диаграмм 1) авч үзсэн.

[1] https://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/tosol201830.pdf
https://www.legalinfo.mn/law/details/14525
[2] http://library.fes.de/pdf-files/bueros/mongolei/16946.pdf
[3] https://www.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=brief_report_2018Q2.pdf&ln=Mn

## Диаграмм 1: Агуулгын хүрээнд суурилсан судалгаа

**Дүрсүүдийг тайлбарлах нь:**

Ромб дүрсээр гэр бүлийн хүчин зүйлтэй холбоотой заалтууд

Зууван дүрсээр төрийн хүчин зүйлтэй холбоотой заалтууд




Судалгаанд тоон болон чанарын судалгааны арга зүйг ашигласан. Асуулгын судалгааны мэдээллийг нэгтгэн шинжлэхдээ нөхцөл байдал, чадамж, капитал гэсэн гурван хүрээнд авч үзсэн. (Бүлэг 2)

Судалгааны үр дүнд дараах үндсэн дүгнэлтийг гаргасан:

**КОВИД-19 цар тахлын үед ихэнх эмэгтэй эзэдтэй бизнесүүдийн нийлүүлэлтийн сүлжээ нь тасарч, худалдаа/үйлдвэрлэлийн хэмжээ нь буурч, зарим тохиолдолд түр болон бүр мөсөн бизнесээ зогсоох эсвэл ажилчдаа халахад хүрсэн байна.** Хэдийгээр хөл хорио нь бүхий л салбарт ямар нэг хэмжээгээр нөлөөлсөн ч, салбарын онцлогоосоо шалтгаалан үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарууд хамгийн их алдагдлыг амссан. Судалгааны үр дүнд, гэр бүлгүй ганц бие эмэгтэйчүүд илүүтэй бизнесээ бүр зогсоосон байхад гэр бүлтэй эмэгтэйчүүд гэр бүлийнхнээсээ дэмжлэг авч байсан байна.

**Төрөөс КОВИД-19 цар тахлын үед бизнес эрхлэгчдэд үзүүлсэн дэмжлэг нь жижиг болон бичил (албан бус) бизнес эрхлэгчдэд хүрч, шаардлагатай дэмжлэг болж чадаагүй байна. Цар тахлын үед төрийн зүгээс үзүүлж байсан** албан дэмжлэг туслалцааг (татварын хөнгөлөлт, мөнгөн тусламж г.м) жижиг болон бичил (албан бус) бизнес эрхлэгч эмэгтэйчүүд хүртэж чадаагүй нь судалгааны үр дүнд гарчээ.

**Хөл хорионы үеийн бизнесийн үйл ажиллагааны доголдлыг дагаад санхүүгийн байдал нь улам хүндэрсэн байна.** Бизнес эрхлэгчдийн орлого буурч, зардал нь өсөж, өр зээл, түрээсийн төлбөрөө төлөхөд хүндрэлтэй болсон гэж мэдээлсэн.

**Бизнес эрхлэгч эмэгтэйчүүд цар тахлын өмнө ч санхүүгийн эх үүсвэрийн дутагдалтай байсан байна.** Тэд бизнесээ тэлж албан ёсны болгоход барьцаа хөрөнгө байхгүй, зээлийн хүү нь хэт өндөр байсан зэрэг хүндрэл бэрхшээлүүдийг дурдав. Харин эрчүүдийн хувьд барьцаа хөрөнгө нь нэг их асуудал болдоггүй гэсэн байна.

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн хувьд гэр **бүлийн бус хүрээлэл буюу найз нөхөд, хөрш, хамт ажилладаг хүмүүсийн дэмжлэг их чухал гэж үзэж байгаа ч, харамсалтай нь тэд ямар нэгэн холбоо эсвэл хүрээлэлд гишүүнчлэлгүй байна.** Бизнес эрхлэгч эмэгтэйчүүд ерөнхийдөө олон нийтийн үйл ажиллагаанд хамрагддаггүй байсан байна. Жишээлбэл, санал асуулгад оролцогчдын 79 хувь нь ямар нэгэн бизнес эрхлэгчдийн хүрээлэл эсвэл холбоонд харьяалалгүй гэж хариулжээ. Мөн, ямар нэгэн холбоонд харьяалалтай ч КОВИД-19 цар тахлын үеэр холбооны зүгээс ямар нэг санхүүгийн болон санхүүгийн бус туслалцаа дэмжлэг үзүүлээгүй гэж хариулсан байна.

**Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд зориулсан мэдээллийн хүртээмж дутмаг байна.** Санал асуулгад хамрагдсан эмэгтэйчүүдийн 90 хувь нь салбарынхаа мэдээллийг хэрхэн авахаа мэддэггүй гэжээ. Гэр бүлийн байдал, бизнесийн байршил, хөгжлийн бэрхшээлтэй эсэх зэрэг хүчин зүйлээс үл хамааран ерөнхийдөө эмэгтэйчүүдийн дунд мэргэжлийн болон салбарын тухай мэдлэг, ойлголт дутмаг байна.

**Дийлэнх эмэгтэйчүүд бизнесийн холбогдолтой мэдлэг чадвараа дээшлүүлэх сонирхолтой байна.** Санал асуулгад оролцогчдын 60-аас дээш хувь нь албан бүртгэл, НӨАТ, татвар г.м төрийн удирдлагатай холбоотой мэдлэгээ дээшлүүлэх, мөн оюуны өмч, бизнесийн стратеги, борлуулалтын стратеги, санхүүгийн менежмент, түгээлт болон зах зээлийн судалгаа хэрхэн хийх талаар сурах сонирхолтой гэжээ.

**Цар тахлын үед эмэгтэйчүүдийн цалин хөлсгүйгээр хийж гүйцэтгэдэг ажил үүрэг улам нэмэгдсэн байна.** Хэдийгээр зарим эмэгтэйчүүд гэр бүлийнхэнтэйгээ их цаг өнгөрөөх боломжтой болсон гэж хариулсан нь эерэг үр дүн мэт боловч, нөгөөтэзгүүр бизнесийн үйл ажиллагаа нь багасаж орлого буурсан, мөн эмэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цаг нэмэгдсэн гэж үзжээ.

**Зарим эмэгтэйчүүдийн хувьд бизнесийн орлого буурах нь гэр бүлийн харилцаанд сөрөг нөлөө үзүүлжээ.** Цөөн тооны эмэгтэйчүүд гэр бүлийн орчиндоо сөрөг хандлага болон хүчирхийлэлтэй нүүр тулсан байна. Судалгаанд оролцогчдын 8 хувь нь сөрөг, заналхийлсэн зан авир, хүчирхийлэлтэй нүүр тулсан гэж хариулсан бөгөөд тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд бусад эмэгтэйчүүдтэй харьцуулахад 2-3 дахин илүү хүчирхийлэлд өртсөн байна.

Судалгаанд оролцогчдын гуравны нэг нь **олон нийтийн газар ганцаараа бизнес эрхлэхээс зайлсхийдэг байна.** Улаанбаатар хотод бизнес эрхэлдэг, тэр дундаа худалдааны салбарт ажилладаг эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн адил эрсдэлд түлхүү өртдөг байна.

Судалгааны 2-р бүлэгт агуулгын, 3-р бүлэгт капитал хөрөнгийн, 4-р бүлэгт чадамжийн хувьд гарсан ололт, 5-р бүлэгт дүгнэлт, 6-р бүлэгт үр дагаврын талаарх мэдээллийг оруулсан бөгөөд эдгээр бүлгүүдээс илүү нарийвчлан тайлбарласан судалгааны үр дүнг харах боломжтой.

# 1 ХАНДЛАГА БОЛОН АРГА ЗҮЙ

Энэхүү үнэлгээг KORE Global болон Азийн сангийн боловсруулсан 5C нөхцөл байдлын өгөгдлийн судалгааны арга зүйд тулгуурлан хийсэн. КОВИД-19-ын нөлөөллийг судлахдаа цар тахлыг даван туулахад бизнест нэн чухал хүчин зүйлс болох орчин нөхцөл, капитал хөрөнгө болон чадамжид илүү анхаарсан. Судалгааны багийн зүгээс аль болох ЭЭЧБ төсөлтэй уялдуулахыг хичээсэн бөгөөд хамааралтай хэсгийг Зураг 1-т улаан цагаригаар  дугуйлан харуулсан болно.



Зураг 1: Монгол дахь Азийн Сангийн судалгааны хамрах хүрээ




Үнэлгээ нь тоон болон чанарын гэсэн хоёр үндсэн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ.

Зураг 2: Үнэлгээний бүрэлдэхүүн хэсэг

| | |
|---|---|
| Бүрэлдэхүүн хэсэг 1: Тоон үнэлгээ (бүгд эмэгтэй) | Бизнес эрхлэгч 400 эмэгтэй судалгаанд оролцсон. |
| Бүрэлдэхүүн хэсэг 2: Чанарын үнэлгээ (эмэгтэй эрэгтэй бизнес эрхлэгчид ) | Эмэгтэй болон эрэгтэй бизнес эрхлэгчдийн дунд 24 кейс судалгаа, 48 чиглүүлэгтэй ярилцлага хийсэн. |

Тоон судалгаанд Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэг, Булган, Дорнод, Сэлэнгэ, Увс аймгийн жижиг болон бичил (албан бус) бизнес эрхлэгч 400 эмэгтэй оролцсон. Эдгээрээс 391 нь бичил бизнес, ес нь жижиг бизнес эрхэлж байна.

Чанарын судалгаанд 36 эмэгтэй, 36 эрэгтэй нийт 72 хүн оролцсон. Үүнд чиглүүлэгтэй ярилцлагыг 24 эмэгтэй, 24 эрэгтэй нийт 48 бизнес эрхлэгчтэй хийсэн ба 24 кейс судалгаар 12 эмэгтэй, 12 эрэгтэй бизнес эрхлэгчдийн дунд явуулсан.

Тоон болон чанарын судалгааны мэдээллийн нэгтгэлийг Хавсралт 1-ээс харна уу.

# 2 СУУРЬ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ

## 2.1 Төрийн болон өрхийн хүчин зүйлийн нөхцөл байдал

### 2.1.1 Төрийн хүчин зүйл

Энэхүү үнэлгээний тайлангийн хүрээнд төрийн болон өрхийн нөхцөл байдлын хүчин зүйлсийг илүү нарийвчлан авч үзсэн. 5C агуулгын хүрээнд дурдсан "нөхцөл байдал" хэмээх ойлголт нь дараах дөрвөн агуулгыг багтаасан:

- **Өрхийн** түвшин дэх эрх мэдлийн хуваарилалт ба өөрчлөлт, хөдөлгөөн;
- **Олон нийтийн** түвшин дэх хандлага болон хэм хэмжээ;
- **Зах зээлийн** болон үйлчилгээний боломж, хүртээмжтэй байдал, хэрэглээ;
- **Төрийн** хууль тогтоомж, бодлого, зохицуулалтууд.

Энэ бүлэгт нэг талаас эзэмшигчийн гэр бүлийн байдал, гэр бүлдээ гүйцэтгэж буй үүрэг оролцоо, шийдвэр гаргалт зэрэг өрхийн харилцаа болон эрх мэдлийн хуваарилалт, нөгөө талаас КОВИД-19 цар тахлын үед Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ болон бодлогын зохицуулалт зэрэг төрийн хүчин зүйлс нь цар тахлын үеэр эмэгтэй болон эрэгтэй бизнес эрхлэгчдэд бизнесээ авч үлдэхэд нь хэрхэн тусалсан эсвэл саад болсон эсэхийг харуулна. Диаграмм 2-т судалгааны үр дүнд гарч ирсэн, бизнес эрхлэгчдэд нөлөөлдөг өрхийн болон төрийн зүгээс үзүүлсэн хүчин зүйлсийг нарийвчлан харуууллаа.

Диаграмм 2: Судалгаанаас урган гарсан агуулгын хүчин зүйлс



### 2.1.1.1 Төрийн зохицуулалтын арга хэмжээнүүд

Монгол Улсын Засгийн Газар (МУЗГ) нь КОВИД-19 цар тахлын өдөр тутмын амьдралд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь жижиг болон бичил (албан бус) бизнес эрхлэгчдэд шууд болон дам байдлаар нөлөөлөл үзүүлсэн байна. Тухайлбал, 2020 оны 12 дугаар сар гэхэд авсан арга хэмжээ нь бизнес эрхлэгчдэд шууд болон дам байдлаар хэрхэн нөлөөлснийг авч үзье.

**Шууд нөлөөлсөн арга хэмжээнүүд:**

- МУЗГ-ын 39 дүгээр тогтоолын дагуу хилийн боомтыг түр хааж, нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах шийдвэр гарсан.[4]

- МУЗГ-ын "Коронавируст халдварын цар тахлын үед (КОВИД-19) айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай" 211 дугаарт тогтоолын дагуу "Айл өрхийн болон дор дурдсанаас бусад аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, уур болон халаалтын хэрэглээний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс тооцож 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд төрөөс хариуцан төлөх" шийдвэр гарсан.[5]

- КОВИД-19-тэй холбоотойгоор Монгол Улсын эдийн засагт хүндрэл учирч, банкны салбарын зээлийн эргэн төлөлтөд доголдол үүсэж байгаатай холбогдуулан, Монгол Банкнаас тодорхой зохицуулалтын дагуу түр хугацаагаар буюу 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрөөс 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хэрэгжүүлэхээр, зээлийн ангилал, эргэн төлөлтөд түр хугацаагаар өөрчлөлт оруулах журам гаргасан.[6]

- 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр Монгол Улсын Их Хурлын (УИХ) нэгдсэн чуулганаар 2020 оны 4 дүгээр сарын 1-ээс 2020 оны 10 дугаар сарын 1-нийг хүртэл хэрэгжүүлэх (I) ажил олгогч болон албан хаагчдыг нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх; (II) хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх; (III) аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх хуулийн тогтоолыг баталсан.[7]

**Дам арга хэмжээнүүд:**

- "КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай" хуулийн 7.1.8-д өмчийн хэлбэр үл харгалзан бүх шатны боловсролын байгууллагын хичээл, сургалтын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар теле, цахим хэлбэрт шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулах гэж заасан байна. Хуулийн дагуу КОВИД-19 цар тахлын хугацаанд ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгийн үйл ажиллагаа цахим болон теле хэлбэрт шилжсэн.

- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоол буюу "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 1.1.1.1 дүгээр зүйлд "Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн цар тахлын үеийн нэмэгдлийг 2020 оныг дуустал үргэлжлүүлэн олгоно" хэмээн тусгасан.

КОВИД-19 цар тахлын тархалтын харилцан адилгүй нөхцөл байдлаас шалтгаалан орон нутгийн түвшинд авч хэрэгжүүлж буй зохицуулалтын арга хэмжээ нь харилцан адилгүй байв.

---

[4] Монгол Улсын Засгийн Газрын Тогтоол - Дугаар 211 - Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай, 1-р зүйл, 2020 оны 12 сарын 3

[5] https://www.mongolbank.mn/news.aspx?tid=1&id=2472

[6] https://www.pwc.com/mn/en/tax_alerts/pdf/tax_alert_04_2020.pdf

[7] Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолын хавсралт - Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр – 1.1.1.1-р зүйл

#### 2.1.1.2 КОВИД-19-ын үеийг даван туулахад төрийн зүгээс үзүүлсэн эерэг дэмжлэг

**МУЗГ-аас нь айл өрхүүд болон бизнес эрхлэгчдийн ашигладаг цахилгаан болон дулааны хангамж гэх мэт урсгал зардлыг бууруулж, хөнгөлөлт үзүүлснээр КОВИД-19-ын эрсдэлийг багасгахад тусалжээ.** Чанарын судалгааны үр дүнгээс харахад КОВИД-19 цар тахлын нөлөөг бууруулах чиглэлээр МУЗГ-ын авч хэрэгжүүлсэн цахилгаан, дулааны төлбөрийн хөнгөлөлт олгох МУЗГ-ын 211-р тогтоол нь жижиг болон бичил (албан бус) бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлсэн арга хэмжээ болсон байна. Энэхүү тогтоосон хугацаанд ус, ариутгах татуургын үйлчилгээ, энгийн хог хаягдлын үйлчилгээг КОВИД-19-ын өмнөх үеийн хэрэглээтэй харьцуулан МУЗГ хариуцан төлөхөөр болсон. Тус шийдвэр нь хүйс, бизнесийн төрлөөс үл хамааран судалгаанд оролцогчдод эергээр нөлөөлсөн байна. Жишээлбэл, жижиг болон бичил (албан бус) бизнес эрхлэгчдийн бизнес гэнэт зогсож, санхүүгийн эх үүсвэргүй болох үед дээрх шийдвэр, урамшуулал нь тодорхой хэмжээгээр сайн дэмжлэг болсон нь харагдаж байна.

***Жишээ 1: МУЗГ-ын шийдвэрийн эерэг нөлөө(нүүд)***

*Цахилгаан дулааныг тэглэсэн нь сайнаар нөлөөлж байгаа. Манай үйлдвэр цахилгаанаар халдаг сард 300,000 төгрөг гардаг байсан. Энэ шийдвэрт маш их баярлаж байна. Зээлийн эргэн төлөлтөө сүүлийн 6,7 сард төлж чадаагүй. Энэ нь жижиг бизнес эрхэлдэг бид нар шиг хүмүүст хүнд тусаж байгаа. Хэрвээ хүргэлтийн үйлчилгээ байвал, байгаа үлдсэн хэдэн бараагаа зараад орлого олмоор байна. Манайх зөвшөөрөлтэй газар нь ороогүй учраас ажиллаж чадахгүй байна. Цаашдаа яаж үргэлжлэх нь ойлгомжгүй байгаа болохоор шийдвэр гаргахад хүнд байна. Ямар нэгэн аргаар захиалагчийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн ч хүргэж өгч чадахгүй байна.*

*Бизнес эрхлэгч – эмэгтэй –*
*Сонгинохайрхан дүүрэг – гар урлал*

**Олон төрлийн хязгаарлалтын улмаас дийлэнх жижиг болон бичил (албан бус) бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн борлуулалт багассан ч, хил хаагдсантай холбоотойгоор зарим бизнес эрхлэгчдийн орон нутгийн буюу дотоодын худалдан авалт нэмэгдэж, борлуулалтад эергээр нөлөө үзүүлсэн байна.** МУЗГ-ын 39-р тогтоолын дагуу хилийн боомтыг түр хугацаагаар хааж, нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах шийдвэрээс үүдэн нэг талаас бараа материалын хомсдол үүсэж, цаашлаад инфляц нэмэгдсэн, нөгөө талаас хил хаасан нь орон нутгийн худалдан авагчдын тоог нэмэгдүүлж, иргэд дотоодын бүтээгдэхүүнээ илүү худалдан авдаг болж, судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн цөөн хэсэгт (2 хувь) эерэг үр дүн мэдрэгдэн КОВИД-19-ын үеэр борлуулалтаа нэмэгдүүлж чадсан гэж хариулсан байна.

**МУЗГ-аас авч хэрэгжүүлсэн өрх гэрүүдэд мөнгөн тэтгэмж олгох арга хэмжээ нь жижиг болон бичил (албан бус) бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд дэмжлэг болж чадсан байна.** Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын дагуу МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.1.1 дэд хэсэгт "Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн цар тахлын үеийн нэмэгдлийг 2020 оныг дуустал үргэлжлүүлэн олгоно" гэсэн. Жижиг тэр дундаа бичил бизнес эрхлэгчдэд төрийн дэмжлэгийг албан хэлбэрээр хүртэхэд бэрхшээлтэй байдаг ч, дээрх шийдвэр нь жижиг болон бичил (албан бус) бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд санхүүгийн хувьд тодорхой хэмжээгээр дэмжлэг болсон байна. Ялангуяа өрх толгойлсон эмэгтэйчүүд болон 17-оос доош насны хүүхэдтэй эмэгтэйчүүд энэхүү мөнгөн тэтгэмжийн үр өгөөжийг хүртсэн байна.

***Жишээ 2: МУЗГ-ын шийдвэр эергээр нөлөөлсөн.***

*Манай ээж хүүхдээ харахад минь тусалдаг. Заримдаа охиноо хадмуудаараа харуулдаг. Төрөөс хүүхдийн мөнгийг 100,000 болгосон нь их тус болсон.*

*Бизнес эрхлэгч – эмэгтэй –*
*Улаанбаатар хот – үйлчилгээ*

***Жишээ 3: Гэр бүлийн харилцаа сайжирсан.***

*Гэр бүлийн харилцаа сайжирч, бүх зүйлсийг хамтдаа хийдэг болсон. Эрүүл мэнд сайжирч, дасгал биеийн тамир хийдэг болж, жин хаясан. Бид өмнө нь ийм их цаг хамтдаа өнгөрүүлж байгаагүй.*

*Бизнес эрхлэгч – эмэгтэй – Улаанбаатар хот – гэр урлал*

**КОВИД-19-ын өмнөх үетэй харьцуулбал жижиг болон бичил (албан бус) бизнес эрхлэгч эмэгтэйчүүд Засгийн Газраас авч хэрэгжүүлсэн хөл хорионы үед гэр бүлтэйгээ илүү их цаг зарцуулах боломжтой болжээ.** Чанарын судалгааны үр дүнгээс харахад бизнес эрхлэгч эмэгтэйчүүд хүүхдүүддээ илүү их цаг зав гаргах боломжтой болсон ба энэ нь цаашлаад гэр бүлийн уур амьсгалд эерэг нөлөө үзүүлж байгааг дурджээ. Харин эрэгтэй бизнес эрхлэгчдийн хувьд бизнесийн нөхцөл байдал бүрэн өөрчлөгдсөн ч, гэр бүлийн харилцаанд гарсан өөрчлөлт эсвэл өрхийн түвшинд гүйцэтгэдэг үүргийн өөрчлөлтийн талаар огт дурдаагүй байна.

### 2.1.1.3 КОВИД-19-ын үеийг даван туулахад төрийн зүгээс учруулсан хүндрэл бэрхшээл

**МУЗГ-аас авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээ нь бүх салбарын бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаар мэдэгдэхүйц байдлаар хязгаарлаж байгаа дүр зургийг чанарын судалгааны үр дүн харуулж байна.** Чанарын болон тоон судалгааны үр дүнгээс харахад МУЗГ-аас хэрэгжүүлж буй бизнес эрхлэлтэд чиглэсэн дэмжлэгийн арга хэмжээ нь бичил (албан бус) бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн бизнест төдийлөн хамааралгүй, нөлөө үзүүлэхүйц байгаагүй аж.

**Ихэнхдээ эмэгтэй эздтэй бизнесүүд цар тахлын хор уршгийг бууруулах арга хэмжээнд өртсөн ч, татварын хөнгөлөлт болон мөнгөн тусламж зэрэг хөнгөлөлтийг хүртэж чадаагүй байна.** Чанарын судалгаагаар МУЗГ-ын хэрэгжүүлсэн арга хэмжээ нь бүхий л салбарын үйл ажиллагааг хязгаарласан гэж дүгнэжээ. Мөн чанарын судалгаанаас гадна тоон судалгаанд МУЗГ-аас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь бүхий л салбарын бизнесийн үйл ажиллагааг зогсооснoос гадна, бичил (албан бус) бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд ямар ч эерэг нөлөө үзүүлээгүй гэсэн байна.

**Бизнест ээлтэй гэж үзэж болохуйц арга хэмжээнүүд нь эмэгтэй эздтэй албан бус бизнест огт нөлөө үзүүлээгүй байна.** Зураг 4-т харуулсанчлан, бизнест ээлтэй гэж үзсэн арга хэмжээнүүд нь (үүнд: мөнгөн дэмжлэг, татвар чөлөөлөх гэх мэт) эмэгтэй эздтэй жижиг болон бичил (албан бус) бизнест огт нөлөө үзүүлээгүй байна. Ялангуяа, эмэгтэй бизнес эрхлэгчдийн дийлэнх нь мөнгөн дэмжлэг (нийт оролцогчдын 78 хувь) болон татвараас чөлөөлөх арга хэмжээ (нийт оролцогчдын

Зураг 3: КОВИД-19 цар тахлын үеийн бизнесийн үйл ажиллагаа



Зураг 4: Эмэгтэй бизнес эрхлэгчдэд КОВИД-19 цар тахлын эсрэг авсан бодлогын түвшний арга хэмжээний нөлөөлөл




74 хувь) нь тэдний бизнест ямар ч нөлөө үзүүлээгүй гэж хариулжээ. Учир нь бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн ихэнх нь бичил буюу албан бус/албан ёсны бүртгэлд хамрагдаагүй бизнес эрхэлдэг, мөн холбогдох шаардлагыг хангадаггүй учир бодлогын дэмжлэг авах эрхгүй байсан юм.

**Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа хаагдсан нь эмэгтэй эздэтэй бизнест сөргөөр нөлөөлсөн.** Хүүхдүүдтэй холбоотой үүрэг, хариуцлага нэмэгдсэн тул бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд бизнес, гэр бүлийнхээ үүрэг хариуцлагыг зэрэг зохицуулахад бэрхшээл тулгарч эхэлсэн байна. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.8-д заасан боловсролын сургууль болон цэцэрлэгийн үйл ажиллагаар цахим болон теле хэлбэрт шилжүүлэх[8] шийдвэрээс шалтгаалж бизнес эрхлэгчдэд хүүхдээ харах, хичээл сурлагад нь анхаарангаа бизнесээ эрхлэх шаардлага тулгарсан байна.

***Жишээ 4: КОВИД-19 цар тахлын үед хүүхэд харахад гарсан бэрхшээл***

*'Ганц бие ээж учраас хүүхдээ харах, асрах асуудал тулгарсан. КОВИД-19-ын өмнө хамаатан дүүгээрээ харуулах, өдөр өнжүүлэхэд өгөх, хүүхэд асрагч авах гэх мэт байдлаар зохицуулдаг байсан. Дүү маань манай охинтой чацуу хүүхэдтэй учраас тусалдаг.*

*Бизнес эрхлэгч – эмэгтэй –*
*Улаанбаатар хот - худалдаа*

**КОВИД-19 цар тахлын үеэр эмэгтэй эздэтэй бизнесийн үйл ажиллагаанууд дотоодын борлуулалт буурах, хаагдах, цомхотгол хийх, нийлүүлэлт тасалдах зэрэг бизнесийн сөрөг үр дагаварт илүү өртсөн байна.** Судалгаанд оролцогчдын дийлэнх нь цар тахлын уршгаар дараах томоохон хоёр асуудалтай нүүр тулжээ. 1-т 84 хувийнх нь борлуулалт буурсан, 2-т 48 хувь нь бизнесээ түр эсвэл бүр мөсөн хаахад хүрчээ.

[8] Монгол Улсын Засгийн Газрын тогтоол – Дугаар 39 - Хилийн зарим боомтыг түр хаах, нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах тухай, 2020 оны 1 сарын 31

Зураг 5: Эмэгтэйчүүдийн өмчит бизнест КОВИД-19-ын үзүүлсэн сөрөг нөлөө болон бэрхшээлүүд




Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн ихэнх нь (88 хувь) КОВИД-19 цар тахал нь тэдний бизнест сөргөөр нөлөөлж бизнесээ хумихад хүргэсэн гэжээ. Үүнээс үзэхэд КОВИД-19 нь тогтмол үйл ажиллагаатай байсан албан, жижиг болон бичил (албан бус) бизнесийн хүртэл (нийт аж ахуйн нэгжүүдийн 27 хувь) нийлүүлэлтийг нь тасалдуулж, дотоодын борлуулалтыг бууруулан, зээлийн эргэн төлөлтийг хоцроох зэрэг сөрөг нөлөө үзүүлсэн байна.

**Төрөөс тогтоож буй хязгаарлалтуудын талаар богино хугацаанд тулгаж мэдээлж байсан нь нийт бизнес эрхлэгчдэд хүндрэл бий болгосон.** Чанарын судалгааны үр дүнгээс харахад эмэгтэй эрэгтэй бизнес эрхлэгчдийн аль аль нь бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг хязгаарлах тухай МУЗГ-аас гаргасан уялдаа холбоогүй, алдаатай шийдвэрт шүүмжлэлтэй хандаж байлаа. Тухайлбал, МУЗГ-аас бизнесүүдийг хаах тухай харьцангуй богино хугацаанд буюу гэнэт мэдээлж байсанд шүүмжлэлтэй хандаж байна. Ялангуяа, гэнэт гаргаж буй эдгээр шийдвэрүүдийн улмаас хаахаасаа өмнө зохих арга хэмжээ авах, бэлтгэл хангах ямар ч боломжгүй байжээ.

Судалгаанд оролцогч эмэгтэй эрэгтэй бизнес эрхлэгчдэд бизнесээ үргэлжлүүлэхэд нь дараах нийтлэг бэрхшээлтэй асуудал ижил тулгарчээ. Үүнд:

- Орлого буурсан
- Худалдан авагч болон үйлчлүүлэгчдийн тоо буурсан

***Жишээ 5: Материалын дутагдал үүссэнээс шалтгаалан үйлдвэрлэл зогссон, ажилчдын цомхотгол хийсэн***

*11 сарын турш хатуу хөл хорионд орсны улмаас хэд хэдэн бэрхшээл тулгарч байгаа. Үүнд бараа материал татаж авч чадахгүйн улмаас үйлдвэрлэл зогссон. Олноор бөөгнөрөхийг хориглосон шийдвэр гарсан учраас үйлдвэрлэл явуулах боломжгүй болсон. Тогтсон цаг хугацаандаа ажилчдын цалин урамшууллыг олгож чадахгүй байна. Тавилгын төрөл зүйлээ нэмэхээс илүү тогтвортой үйл ажиллагаа явуулж ажиллахыг хичээж байгаа. Үйл ажиллагаа явуулаад удаж байгаа болохоор байнгын худалдан авагч байгаа. 3Г-аас хүргэлтийн үйлчилгээг эрсдэлтэй бүлэгт хамааруулж үзсэн учраас бүтээгдэхүүн хүргэж өгч чадахгүй байгаа. Өөрсдийн гэсэн газар түрээслэж үйл ажиллагаа явуулдаг. 4 жилийн хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулж, тогтмол түрээсийн төлбөрийг төлдөг байсан учраас түрээслэгч тал энэхүү нөхцөл байдлыг харгалзан үзэж түрээсийн төлбөрийг хойшлуулж өгсөн. Үйлдвэр, дэлгүүрийн ажилчид нийлээд 20 гаруй хүнтэй байсан. Одоо цомхтоод 5 ажилчинтай үлдсэн.*

*Бизнес эрхлэгч – эмэгтэй – Улаанбаатар хот – тавилга үйлдвэрлэл*

- Санхүүгийн хүндрэл тулгарсан
- Бараа материалын олдоц багасаж, үнэ нэмэгдсэн
- Зээлийн эргэн төлөлттэй холбоотой бэрхшээл гарсан
- Түрээс төлөх чадваргүй болсон г.м

**Таван бизнес эрхлэгч тутмын нэг нь "бизнесээ бүр мөсөн хаасан" байна.** Бизнес нь зогссон оролцогчдын дийлэнх нь буюу 95.5 хувь нь хаах болсон шалтгаан бүхэлдээ болон зарим талаараа цар тахалтай холбоотой гэж хариулжээ. Эндээс КОВИД-19 цар тахлын нөлөөнөөс үүдэн эмэгтэй эзэдтэй бизнесүүд түр болон бүрэн хаагдсан гэж хэлж болохоор байна. Нийлүүлэлтийн сүлжээ, импорт, борлуулалт буурах, түр хугацаагаар хаагдах зэрэг бараг бүх бэрхшээл нь халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор МУЗГ-аас авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд буюу гадны хүчин зүйлээс үүдэлтэй байна.

**Бизнес нь түр хаагдаж, нийлүүлэлт тасалдсан нь эдийн засгийн хямралын бас нэг нийтлэг үзэгдэл болох ажилгүйдэлд хүргэжээ.** Үйлдвэрлэлийн хэмжээ буурсан (бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт хангалтгүйн улмаас) эсвэл нийлүүлэлт тасалдсан нь ажилтнуудаа цомхотгоход хүргэжээ. Судалгаанд хамрагдсан нийт бизнес эрхлэгчдээс КОВИД-19 цар тахлын өмнөх болон цар тахлын үед ажиллаж буй ажилтнуудын тоог харьцуулан харахад, бизнес эрхлэгч эмэгтэйчүүд нийт ажилтнуудынхаа 20 гаруй хувийг цомхотгожээ. Ялангуяа, хагас цагийн ажилтнуудын 42 хувь, бүтэн цагийн ажилтнуудын 18 хувь нь энэхүү цомхотголд илүү өртсөн байна. Цомхотгогдсон ажилтнуудын хувьд хүйсийн хувьд тэдийлэн ялгаа харагдахгүй байгаа нь анхнаасаа дийлэнх ажилчид нь эмэгтэй байсан тул халагдсан ажилчдын дийлэнх нь эмэгтэйчүүд байгаа явдал юм.

**Бизнесийн түүхий эд багасахын хэрээр бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдэж, харин худалдан авагчдын худалдан авах чадвар буурсан нь борлуулалт болон үйлдвэрлэлийн аль аль нь буурахад хүргэсэн.** Судалгаанд оролцогчдын дийлэнх нь түүхий эд материалын хомсдол орж, инфляцын түвшин нэмэгдсэнийг МУЗГ-ын 39-р тогтоолын хүрээнд хилийн боомтын шалган нэвтрүүлэх цэгүүдийг түр хаасантай холбоотой гэж үзсэн.[9] Энэ нь худалдан авах чадвар болон борлуулалтын хэмжээг бууруулахад нөлөөлсөн байна.

**КОВИД-19-ын үед авч хэрэгжүүлсэн тусгай журам, тогтоол нь хот суурин газар үйл ажиллагаа явуулж буй эмэгтэй эзэдтэй бизнесүүдэд сөргөөр нөлөөлсөн байна.** Тоон судалгааны үр дүнгээс харахад КОВИД-19 цар тахлын тархалт болон түүнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлж буй засаг захиргааны арга хэмжээ, хязгаарлалт нь хот суурин газар болон орон нутагт харилцан адилгүй байсан тул, үйл ажиллагаа явуулж буй бизнесүүдэд харилцан адилгүй нөлөөлсөн байна. Хотод бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн 82 хувь нь, хөдөө орон нутагт бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн 67 хувь нь бизнесээ түр болон бүрэн хаажээ. Гэхдээ, хөдөө орон нутгийн хувьд Сэлэнгэ аймагт хөл хорио хамгийн удаан тавигдсан бол бусад гурван аймгийн хувьд КОВИД-19-ын халдварын тохиолдол илрээгүй байсантай холбоотойгоор орон нутгийн дотоод бизнес болон жирийн амьдрал хэвийн өрнөж байжээ.

Хүснэгт 1: Ажилтнуудын тооны өөрчлөлт

| Item | Бүтэн цаг | | | Хагас цаг | | | Нийт | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Нийт | Эмэгтэй | Эрэгтэй | Нийт | Эмэгтэй | Эрэгтэй | Нийт | Эмэгтэй | Эрэгтэй |
| КОВИД-ын өмнө | 1,190 | 919 | 271 | 186 | 130 | 56 | 1,376 | 1,049 | 327 |
| КОВИД-ын дараа | 981 | 761 | 220 | 108 | 73 | 35 | 1,089 | 834 | 255 |
| *Өөрчлөлт, тоогоор* | -209 | -158 | -51 | -78 | -57 | -21 | -287 | -215 | -72 |
| *Өөрчлөлт, %* | 18 | 17 | 19 | 42 | 44 | 38 | 21 | 20 | 22 |

[9] Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолын хавсралт - Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр – 1.1.1.1-р зүйл

***Жишээ 6: Орлого буурч, материалын дутагдал үүссэн***

*Бидний бизнесийн нөхцөл байдалд өөрчлөлт гарч байгаа. Хүмүүсийн санхүүгийн чадвар маш муудсан, хөдөлгөөн багассан цар тахалтай үе болохоор нэг хэсэгтээ ажиллахгүй гээд бүр хаачихсан байсан. КОВИД-19-ээс өмнө өдрийн 8-10 цаг ажилладаг байсан. Өглөө 8 гэж гараад л үд дундад хүүхдүүд дээрээ очиж хоол хийгээд хичээл номоос нь авчхаад 1 цагийн үед буцаж ирээд орой 7 цагийн үед тардаг байсан. Одоо бол өглөө 9-11 хүртэл ажиллаад өдөр 13-17 хүртэл ажиллаад л тарж байгаа. Орлого муудсан, материал сонгох зүйл байхгүй болсон, материалаа татаж авч чадахгүй байгаа. Материалаа урд нь метрийн барааны захаас, хотоос авдаг байсан. Харилцагч, зах зээл багассан. Хүмүүс захиалга хийхээ больсон. Өмнө нь ядаж даашинз оёулдаг байсан бол одоо энгийн өдөр тутмын зүйлсийг л хааяа захидаг байсан бол одоо бараг захиалга байхгүй. КОВИД-19-өөс өмнө өөрөө яваад авчихдаг байсан бол одоо материалаа ерөөсөө авч чадахгүй байна. Материал татан авалт байхгүй болчихсон ажил гацчихсан зээл авч чадахгүй байгаад байгаа. Материалын үлдэц 300,000 төгрөгийн орчим л байна. Одоо зөвхөн хүмүүс над дээр материалаа өөрсдөө барьж ирээд хийлгэж байгаа.*

*Бизнес эрхлэгч – эмэгтэй –*
*Увс аймаг - оёдол*

Чанарын судалгааны үр дүнгээс харахад КОВИД-19-ын нөлөө болон үүнээс шалтгаалж буй асуудлууд нь бизнесийн үйл ажиллагаа явуулж буй байршлаас шалтгаалан янз бүрээр илэрч байгаа нь харагдаж байна. Жишээлбэл, хөл хорионы үеэр Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй бичил (албан бус) бизнес эрхлэгчдийн хувьд QR код (хөдөлгөөний хязгаарлалтад орохгүйгээр зорчих эрх бүхий код) машиндаа авах боломжгүй байснаас хүргэлт хийх боломжийг хязгаарлаж байхад хөдөө орон нутагт тухайн аймаг доторх хэсэгчилсэн хязгаарлалт нь түгээлт хүргэлтийн үйлчилгээнд сөргөөр нөлөөлжээ. Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулдаг бизнесүүд хот дотроосоо түүхий эдээ ямар нэгэн саад бэрхшээлгүй авч байсан ч, хөдөө орон нутаг руу зорчиход хүндрэлтэй болсон.

***Жишээ 7: Хөл хорионы үед түгээлтийн явцад тулгарсан асуудал***

*Үндэсний болон орон нутгийн хэмжээнд КОВИД-19-той холбоотойгоор гаргаж буй бизнес эрхлэгчдэд нөлөөлөхүйц шийдвэр маш муу байна. Яг хэрэгжиж байгаа юманд нь танил тал л ашиглагдсан байдаг. Ядаж л QR code -ийн хувьд л олдохгүй байна шүү дээ. Сөргөөр л нөлөөлж байна. Шийдвэр гаргана тэрийг нь хэрэгжүүлэх хүмүүс нь дураараа өөрчлөөд л байна даа.*

*Бизнес эрхлэгч – эрэгтэй –*
*Улаанбаатар хот - худалдаа*

Зураг 6: Эмэгтэй эзэнтэй бизнесийн үйл ажиллагааны нөхцөл байдал, байршлаар (судалгаа хийсэн үеийн байдлаар)



Нийт судалгаанд оролцогчдын тал буюу 49 хувь нь бизнес хаагдах "өндөр эрсдэлтэй", 43 хувь нь "дундаж эсвэл бага" эрсдэлтэй гэж хариулсан бол оролцогчдын зөвхөн 6 хувь нь л өөрсдийн бизнесээ "аюулгүй" эсвэл "эрсдэлд ороогүй" гэжээ. Үйлчилгээний салбарын бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн 70 хувь нь бизнес хаагдах өндөр эрсдэлтэй гэж хариулсан ба бусад салбарын бизнес эрхлэгч эмэгтэйчүүдтэй харьцуулахад хамгийн багадаа л 20 орчим хувиар өндөр байна. **Энэ нь хямралын улмаас жижиг болон бичил (албан бус) бизнесүүдийн дийлэнх нь, тэр дундаа үйлчилгээ болон үйлдвэрлэлийн салбарын бизнесүүд үйл ажиллагаагаа зогсоож бүрэн хаагдах эрсдэлд орсныг харуулж байна.**

КОВИД-19 цар тахлын үед үндэсний, орон нутгийн болон салбарын түвшнээс шалтгаалан харилцан адилгүй бодлого, зохицуулалт авч хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор бизнесүүдэд харилцан адилгүй нөлөөлсөн байна. Тухайлбал, зарим бизнесийг зайлшгүй шаардлагатай гэж үзэн нээлттэй байлгасан бол зарим бизнесийг хүчээр үйл ажиллагааг нь зогсоосон байна. Ялангуяа, МУЗГ-аас үйлчилгээний салбарыг бүрэн эсвэл хэсэгчлэн хаах шийдвэр гаргасантай холбогдуулан үйлчилгээний салбарын 35 хувь, үйлдвэрлэлийн салбарын 23 хувь нь бизнесээ хаасан нь өндөр үзүүлэлт юм. **Үйлдвэрлэл болон үйлчилгээний салбарын бизнес эрхлэгч эмэгтэйчүүд импорт (бараа материал, түүхий эд гэх мэт)**

Зураг 7:  Бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөх эрсдэлийн түвшин, бизнесийн салбараар




Зураг 8: Эмэгтэй эздтэй бизнесийн нөхцөл байдал, салбараар



**болон байнгын үйлчлүүлэгчдээсээ голчлон хамааралтай байдаг тул салбарын онцлогоосоо шалтгаалаад алдагдал их амссан төдийгүй цар тахлын нөлөөнд илүү их нэрвэгдсэн байна.**

Харин улирлын шинж чанартай хөдөө аж ахуйн салбар нь бусад салбаруудтай харьцуулахад цар тахлын нөлөөнд бага өртсөн байна. Гэсэн ч газар тариалан улирлын чанартай байдаг бол мал аж ахуйг жилийн дөрвөн улирал эрхэлж болдог байдлаас хамаарч харилцан адилгүй алдагдал амссан байна.

**Зарим бизнесүүд ажилчдаа эрсдэлээс хамгаалан алсын зайнаас ажиллах боломжийг олгосон бол зарим бизнесүүд шилжилтэд бэлэн биш байсан байна.** Судалгааны үеэр бизнес менежментийн чадавхтай холбоотой янз бүрийн шалтгаанаар, КОВИД-19 нь зарим бизнес эрхлэгчдийн хувьд бизнес нь үргэлжлүүлэн орших эсэхийг шийдэх шалгуур болсон юм.

***Жишээ 8: Хил хааснаас шалтгаалсан асуудал***

*Хамгийн том бэрхшээл бол борлуулалт 50 хувиар багассан. Материалын нийлүүлэлт багассан. Аль болох материалаа өөрсөд рүүгээ татах гэж хичээж байна. Хил хаалттай учраас өнгөний сонголт багасаж, бүтээгдэхүүнийхээ өнгө болон загвараа өөрчилж байна.*

*Бизнес эрхлэгч – эмэгтэй –*
*Чингэлтэй дүүрэг – эсгий урлал*

**Судалгааны үеэр хэд хэдэн эерэг үр дүн цөөн тооны бизнес эрхлэгчдийн дунд гарсан бөгөөд тэд КОВИД-19 цар тахлын арга хэмжээг уян хатан хүлээн авч, нөхцөл байдалд бизнесээ зохицуулах арга хэмжээг авч чадсан байна.** Тоон судалгаа нь КОВИД-19 цар тахлын үеэр эмэгтэй бизнес эрхлэгчдийн 2 хувь нь бизнесээ өргөжүүлж орлогоо нэмэгдүүлж чадсаныг харуулсан. Тухайн бизнесүүд нь шинэ зах зээлийг эрэлхийлж, шинэ бүтээгдэхүүн боловсруулж, ажлын шинэ арга барил нэвтрүүлэн, борлуулалтын шинэ сувгуудыг нээсэн байна. Мөн дотоодын борлуулалтаа нэмэгдүүлж чадсан байна. Чанарын судалгаагаар бизнес эрхлэгч эмэгтэйчүүд эрсдэлээ бууруулах үүднээс онлайн сурталчилгаа болон борлуулалтын суваг руу хандаж ажилласан нь харагдсан. Мөн бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн 22 хувь нь хязгаарлалт, хоригийг давахын тулд бизнесээ илүү уян хатан болгож, түгээлт хүргэлтийн аргаа өөрчлөн, байршлаа сольж, шинэ бараа бүтээгдэхүүн гаргасан байна.

**КОВИД-19 цар тахал нь зарим бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд бизнесээ үнэлж дүгнэх, шаардлагатай чиглэлд бизнесээ тэлэх боломжийг олгосон.** Жижиглэн худалдаа эрхлэгчид нь зарим нэг газар үйл ажиллагаагаа явуулах боломжгүй болсон хэдий ч, онлайн худалдаа түгээлт рүү хөрвөж, бизнесийн чиглэлээ өөрчилсөн байна. Кейс судалгаанууд зарим бизнес эрхлэгч эмэгтэйчүүд онлайн дэлгүүрүүдээр дамжуулан дижитал хэлбэрээр үйлчлүүлэгчдийг татаж борлуулалт хийж байгааг харуулсан. Дийлэнх бизнес эрхлэгч эмэгтэйчүүд борлуулалт маркетингаа дэмжих үүднээс Фейсбүүк сүлжээг ашиглаж эхэлсэн байна. Тэдний зарим нэг нь өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан бүтээгдэхүүний орцыг орлуулж, шаардлагатай түүхий эдийг өөрсдөө бэлтгэн эхэлж, импортоос хамааралтай байдлаа багасгаж эхэлсэн байна. Цөөн тооны эрэгтэй, эмэгтэй бизнес эрхлэгчид хуучин бүтээгдэхүүнүүдээ КОВИД-19 цар тахлын үед үйлдвэрлэхэд хялбар, эрэлттэй шинэ бүтээгдэхүүнээр сольж чадсан байна. Зарим бизнес эрхлэгч эрчүүд өөрийн бүтээгдэхүүнээ бартерлаж шинэ төрлийн хүргэлтийн үйлчилгээ нэвтрүүлэхийг хичээсэн байна.

**Бизнес эрхлэгч эмэгтэйчүүд ялангуяа үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй эмэгтэйчүүд санхүү болон борлуулалтын тасалдлын улмаас шинэ түүхий эд импортлох эсвэл шинэ түүхий эд худалдаж авах боломжгүй болсон тул, үлдсэн нөөцдөө тулгуурлан үйлдвэрлэлээ үргэлжлүүлэн явуулж байна.** КОВИД-19 цар тахлын үед түүхий эд материалын хангалтгүй байдал болон түүхий эдийн өртөг нэмэгдсэнээс шалтгаалан одоо байгаа нөөцөө ухаалгаар зарцуулах шаардлагатай болсныг чанарын судалгааны үр дүнгүүд харуулсан. Бизнес эрхлэгч эмэгтэйчүүд нөөц болон цагаа шинэ бизнесийн үйл ажиллагаанд зарцуулахаас илүүтэйгээр эрэлт хэрэгцээ дээр тулгуурлан, материал болон бизнесийн орцуудаа импортоор авч байна. Тодруулбал, МУЗГ-аас шинээр цар тахлын хязгаарлалтуудыг тогтооход учирч болзошгүй хохирлыг бууруулах зорилгоор бизнес эрхлэгч эмэгтэйчүүд шинэ материал худалдаж авахаа зогсоосон байна. Зарим эмэгтэйчүүд бүтээгдэхүүнийхээ чанарыг алдалгүйгээр орлуулж болохуйц орцуудыг ашиглан өөрсдөө түүхий эдээ бэлтгэж эхэлсэн тохиолдлууд байна.

***Жишээ 9: Шинэ борлуулалтын арга зам нэвтрүүлсэн.***

*Хүмүүсийн худалдан авах чадвар муудаж байгаа. Сардаа 3 хүртэлх сая төгрөгийн орлоготой өмнө нь байсан бол одоо бараг 60-70 хувиар буурсан. 11 сард бүр зогссон харин 12 сард бас арай гайгүй байна. Энэ нөхцөл байдал дасаж эхэлж байна. Эерэг сэтгэгдэл үлдээсэн, КОВИД-ыг боломж гэж хараад хүргэлтийн үйлчилгээ болон цахим чиглэл рүү шилжих талаар ярьж байна.*

*Бизнес эрхлэгч – эмэгтэй –*
*Увс аймаг - оёдол*

Бизнесээ нөхцөл байдалдаа тохируулан өөрчилж чадсан бизнес эрхлэгчид өөрсдийн бизнесийн ирээдүйд илүү итгэлтэй байсан. Ялангуяа КОВИД-19 улмаас алдагдал хамгийн их амссан үйлчилгээ (31 хувь) ба үйлдвэрлэлийн (24 хувь) салбарын бизнес эрхлэгч эмэгтэйчүүд эдгээр нөлөөллийг даван гарахын тулд хамгийн их оролдлого хийжээ. Бизнес эрхлэгч эрэгтэйчүүдтэй харьцуулахад, хоол хүнс, гар урлал зэрэг дасан зохицуулж өөрчлөхөд хялбар салбарт үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн дунд цар тахлын нөлөөг даван туулах оролдлого өндөр байсан.

Мөн түүнчлэн, КОВИД-19-тэй холбоотойгоор өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ өөрчлөх гэж үзсэн бизнес эрхлэгчдийн 54 хувь нь өөрсдийн бизнесийн ирээдүйн орлогыг эргээр төсөөлж байсан бол, ямар нэгэн өөрчлөх арга хэмжээ аваагүй бизнес эрхлэгчдийн 32 хувь нь орлого нь нэмэгдэнэ гэж хариулжээ. Цаг үеийн нөхцөл байдлыг мэдэрч, арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлсэн бизнес эрхлэгчид илүү эрсдэл багатай, сөрөг нөлөөлөлд бага өртөж байгааг харуулж байна.

## 2.1.2 Өрхийн нөхцөл байдал ба бизнесийн дэмжлэг

**Судалгаанд хамрагдсан жижиг болон бичил (албан бус) бизнес эрхлэгчдийн дундаж нас нь 44, бүрэн дунд эсвэл их дээд сургууль төгссөн, гэрлэсэн, нөхөр болон хоёр хүүхдийн хамтаар амьдардаг гэсэн дундаж үзүүлэлттэй байна.** Ерөнхийдөө судалгаанд хамрагдагчдын 52 хувь нь Мэргэжлийн сургалт, үйлчилгээний төв (МСҮТ), коллеж болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байна. Эмэгтэйчүүдийн 93 хувь нь хүүхэдтэй, үлдсэн 7 хувь нь хүүхэдгүй гэжээ. Хүүхэдтэй эмэгтэйчүүдийн бараг 70 хувь нь 17-оос доош насны хүүхэдтэй байна. Судалгаанд хамрагдагчдын ихэнх нь гэрлэсэн. Харин гэр бүл салсан 30 хүн байсан ба тэдний ихэнх нь салсан нөхрөөсөө ямар нэгэн санхүүгийн дэмжлэг авдаггүй гэж мэдээлсэн. Энэ нь өрхийн санхүү ихэнхдээ бизнес эрхлэгч эмэгтэйчүүдээс хамаардаг болохыг харуулж байна. Хүн ам зүйн дэлгэрэнгүй үзүүлэлтүүдийг Зураг 9-өөс харна уу.

Зураг 9: Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин




Зураг 10: Хуучин хамтрагчаасаа санхүүгийн дэмжлэг авдаг байдал




Зураг 11: Гэрлэлтийн байдал




**Тоон судалгааны үр дүнгээс харахад 17-оос доош насны хүүхэдтэй болон хүүхэдгүй бизнес эрхлэгч эмэгтэйчүүд нь хүн ам зүй, нийгэм-эдийн засгийн шинж чанарын хувьд мэдэгдэхүйц ялгаатай байв.** 17-оос доош насны хүүхэдтэй эмэгтэйчүүд харьцангуй залуу, өндөр боловсролтой, бүтэн цагийн ажил хийдэг нөхөр эсвэл хамтрагчтай, мөн/эсвэл тогтмол ажил эрхэлдэг байсан ба харьцангуй давуу талтай байв.

### 2.1.2.1 КОВИД-19-ын үеийг даван туулахад бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлсэн өрхийн хүчин зүйлс

**Эрэгтэй болон эмэгтэй бизнес эрхлэгчдийн хувьд гэр бүлийн гишүүд нь гэрийн орны ажлыг хувааж хийн, бизнесийн үйл ажиллагаанд туслах замаар дэмжлэг үзүүлж байна.** Чанарын судалгаа буюу кейс судалгаа болон чиглүүлэгтэй ярилцлагын үр дүнд бизнес эрхлэгчдэд ойр дотны болон гэр бүлийн гишүүд нь сэтгэл санааны болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлдэг болох нь харагдсан. Өрхийн дэмжлэг нь гэр бүлийн гишүүд ээлжлэн ажиллах, бараа бүтээгдэхүүнийг нь борлуулж өгөх, маркетинг өргөжүүлж өгөх, бүтээгдэхүүнийг нь үйлчлүүлэгчдэд хүргэх зэргээр илэрч байв. Бүтээгдэхүүний найрлага, түүхий эдийг нь бэлтгэж өгөх, ойр дотно хүрээлэл дундаа бүтээгдэхүүний талаарх мэдээллийг тараах зэргээр борлуулалтаа нэмэгдүүлэхэд нь гэр бүлийн гишүүд нь тусалж байв. Ялангуяа үйлчилгээ, үйлдвэрлэлийн салбарын бизнес эрхлэгч эмэгтэйчүүд үйлдвэрлэлийн процессоо хурдасгахын тулд гэр бүлийн гишүүдээсээ дэмжлэг, туслалцаа авсан байна.

***Жишээ 10: Нөхөр хүүгийнхээ дэмжлэгийг авдаг.***

*Гэр бүлээрээ оёдлоо хийдэг. Том хүү, нөхөр ачаалал ихтэй үед хамт оёдог. Хангалттай орлого олж байна. Бизнес таг зогсоогүй байна. Хөдөө орон нутагт малчдын хэрэглээ одоохондоо харьцангүй хэвийн байна. Малчид өвлийн хүйтэнд дулаан хувцас, гутал хэрэгтэй учраас захиалга бага ч гэсэн байна. Цаашид материал дутагдал бий болох байх. Гэр бүлийн хувьд эрүүл мэндийн зөвлөмжөө дагаж, аарц, чацаргана, сүү цагаан идээ хэрэглэж байна. Хоол унды хэрэглээ тэж их буураагүй байна. Хүнсний хэрэглээ хэвийн байна. Боловсролын хувьд сургууль амарчихсан байна. Би бизнесээ эрхэлж байхад нөхөр, хүүхдүүд ар гэрийн ажлаа зохицуулдаг. Ажил, гэрээ зохицуулахад нэг их бэрхшээл гардаггүй.*

*Бизнес эрхлэгч– эмэгтэй –*
*Увс аймаг - оёдол*

**Өрхийн бизнес эрхэлдэг эмэгтэйчүүд гэр бүлийн гишүүдийнхээ тусламжтайгаар хүндрэл бэрхшээлийг давсан байна.** Кейсүүдээс харахад гэр бүлийн бизнестэй, эсвэл нэмэлт ажилтай хүмүүс, мөн гэр бүлийн харилцаа, уур амьсгал сайтай бизнес эрхлэгчид бизнесээ илүү хялбар авч үлдсэнийг харуулж байна.

***Жишээ 11: Бизнесээ эрхлэх явцад гэр бүлийн хүний дэмжлэг өндөр байсан.***

*Нөхөр маань компьютерын программист мэргэжилтэй. Хувиараа программ зохиож хүнд тусалж, веб хийдэг. Хажуугаар нь надад тусалдаг. Би хөлөг оёж, нөхөр маань төмөр ясаар модон тоглоом хийдэг. Бизнесээ хадгалж, хамгаалахын тулд мөн нөхөртэйгөө маш сайн ярилцдаг. Нөхөр маань сайн дэмждэг.*

*Бизнес эрхлэгч - эмэгтэй –*
*Улаанбаатар хот – гар урлал*

**Бизнес эрхлэгч эмэгтэйчүүд хүүхдүүдийнхээ бие даасан байдал болон бизнесийн үйл ажиллагаанд нь тусалдаг болсныг өндрөөр үнэлсэн.** Эмэгтэй бизнес эрхлэгчид хүүхдүүдийнхээ бие даасан байдлыг үнэлж, бизнестээ илүү цаг хугацаа зарцуулах боломж олгодог гэж үзжээ. Бизнес эрхлэгчдийг дэмжих өрхийн хүчин зүйлүүдтэй холбоотойгоор эмэгтэй оролцогчид хүүхдүүдийнхээ бие даасан байдал нэмэгдсэнийг онцолсон байна. Тухайлбал ээж нь бизнестээ анхаараад завгүй байх үед зарим хүүхдүүд нь хоолоо хийж, том хүүхдүүд нь бага дүүгээ хардаг гэх мэт. Хааяа хүүхдүүд нь ээждээ бүтээгдэхүүн савлахад нь тусалдаг байна. Гэр бүлийн бизнестэй эмэгтэйчүүд гэр бүлийн гишүүдийнхээ тусламжтайгаар бэрхшээлүүдийг даван туулсан байна.

### 2.1.2.2 КОВИД-19-ыг даван туулахад бизнес эрхлэгчдийг хязгаарласан өрхийн хүчин зүйлс

Судалгаанд оролцогчид бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн өмнө цар тахлын хүндрэлийг даван туулахад өрх, гэр бүлийн зүгээс үзүүлж буй эерэг болон сөрөг хүчин зүйлийг

дурдсан. КОВИД-19-ын үеэр зарим бизнес эрхлэгчдэд тулгарсан өрх гэртэй холбоотой бэрхшээлүүдийн нэг **цар тахлын үед орлого буурснаас шалтгаалан гэр бүлийн гишүүдийн зүгээс сөрөг хандлага гаргаж байсан явдал** юм. Ийм хандлагыг эрэгтэй, эмэгтэй бизнес эрхлэгчдийн аль аль нь мэдэрчээ.

Мөн эрэгтэй эмэгтэй бизнес эрхлэгчдийн хувьд гэр орны ажил үүргийн хуваарилалт дээр томоохон ялгаа харагдаж байна. **Эмэгтэйчүүд ажил эрхлэлтээс үл хамааран хүүхэд харах, асрах үүргээ гүйцэтгэж байхад, эрэгтэй гэр бүлийн гишүүн хэчнээн цаг зав боломж байсан ч харьцангуй бага цагийг хүүхдээ харж, асрахад зориулж байна.** Тоон судалгааны үр дүнгээс харахад КОВИД-19 цар тахлаас өмнө, 17-оос доош насны хүүхэдтэй бизнес эрхлэгч эмэгтэйчүүд дунджаар 2-3 дахин илүү цагийг гэрийн ажил болон хүүхдээ харахад зарцуулжээ. Ялангуяа, хүүхэд өвчтэй байхад асаргаа нь даруй 10 дахин нэмэгддэг байна. Гэрийн болон асаргаа халамжийн үүрэг нь цар тахлын үеэр улам нэмэгдсэн байна. Зураг 12-т үзүүлсэнчлэн судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн бараг тал нь буюу 46 хувь нь нөхөртэйгөө адил тэнцүү хувиар хүүхдүүдтэйгээ цагийг өнгөрөөдөг гэж хариулсан бол, 1/3 буюу 32 хувь нь илүү ачаалал үүрдэг, 14 хувь нь нөхөр нь илүү ачаалал үүрдэг гэж хариулсан байна. Бусад тохиолдолд хүүхдийнхээ хичээлийн хуваарийг хянах, өвчтэй хүүхдээ асрах, гэр орны ажил хийх зэрэг нь ихэнхдээ эмэгтэйчүүдийн хариуцлага болдог байна. 1/5 -1/3 хэсэг нь буюу маш цөөн эмэгтэй энэ үүрэг хариуцлагаа хамтрагчтайгаа адил тэнцүү үүрдэг, мөн бүр бага хувь нь гэр бүлийн гишүүд болон нөхрүүд нь илүү их үүрэг хариуцлага хүлээдэг гэж хариулжээ. Санал асуулгад оролцсон эмэгтэйчүүдийн тал хувь нь өөр бусад гэр орны ажлаас гадна дээрх бүх үүрэг хариуцлагыг үүрдэг гэж хариулсан байна.

Судалгааны үр дүнгээс харахад эрэгтэй бизнес эрхлэгчид илүү өөрийн бизнестээ анхаардаг бол эмэгтэй бизнес эрхлэгчид бизнес болон гэр бүлээ хоёуланг нь зэрэг зохицуулдаг байна. **Гэр бүлтэй бизнес эрхлэгч эрэгтэйчүүд нөхцөл байдлаас үл хамааран ажил бизнестээ ихэвчлэн анхаарч байхад, гэр бүлтэй бизнес эрхлэгч эмэгтэйчүүд өрх гэр болон бизнестээ давхар анхаарах шаардлагатай болсон байна.**

Гэр бүлийн түвшинд хосууд хүүхэдтэйгээ ижил тэнцүү цагийг хамтдаа өнгөрүүлж, тоглодог байна. Гэхдээ чанарын судалгаагаар “КОВИД -19 цар тахлын үед хэн нь гэр орны ажил хийж, хүүхдээ асран, өвчтэй үед нь харах вэ” гэдгийг гэр бүлийн хүрээнд илүү тодорхой болговол гэр бүлийн харилцаанд сайн нөлөөтэй хөндсөн. Судалгаанд оролцогч эмэгтэйчүүдийн бараг тал хувь нь дээр дурдсан үүрэг болон бусад гэрийн ажлыг тэд хийдэг гэж хариулжээ.

Зураг 12: Арван долоогоос доош насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийн гүйцэтгэдэг үүрэг



**Кейс #1 : "Албан бизнес эрхлэгчид олон бэрхшээлтэй тулгардаг тул би бизнесээ албан болгохгүй гэж бодож байна" Гар урлалын салбарын бичил (албан бус бизнес эрхлэгч эмэгтэй**

Өөрийн бизнесээ эхлүүлж эсгий урлал хийж эхэлснээс хойш 4 жил өнгөрсөн байна. Өөрийн гэсэн орлоготой болохын тулд би 2013 онд хүүхдээ хараад гэртээ байж байх хугацаандаа интернэтээр судалж байгаад эсгий урлал хийж сурсан. Би Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэгт амьдардаг. Анх эсгийгээр бүтээгдэхүүн хийгээд интернэтэд тавьсан чинь цэцэрлэгийн багш нар хүүхдүүдэд зориулж үлгэрийн баатар хийх боломжтой эсэхийг асууж байсан. Тиймээс гэрийнхэн түр зуур гэртээ хүүхдээ харахдаа хийх гэж байгаа бизнес мэтээр харж байсан хэдий ч, би цэцэрлэгийн хүүхдүүдэд зориулж  эсгий тоглоомууд хийж эхэлсэн. Энэхүү бизнесийн санаа надад маш их таалагдаж байснаас гадна манай нөхөр маш их дэмжиж байсан. Гэрээ оффис болгож ашигладаг ба Хас банкны жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зээлийг авах гэж үзэж байсан боловч барьцаа хөрөнгө байхгүй мөн бизнес маань бүрэн хөгжөөгүй гэдэг шалтгаанаар зээл авч чадаагүй юм. Үүний дараа хүүхдийн мөнгийг бизнесээ эхлэхэд ашигласан. Банк зээл олгохдоо орлого зарлагыг компанийн хэмжээнд авч үзээд байдаг гэвч жижиг бизнес эрхлэгчдэд тийм санхүүгийн тайлан байдаггүй.

Би Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн Төвийн (БЭЭТ) сургалтад оролцож байсан. БЭЭТ жижиг бизнесүүдэд зээл авахад хүндрэлтэй байдаг тул бизнесээ эхлэхдээ хөрөнгө оруулалттай байх хэрэгтэй талаар зөвлөсөн. Манай ээж бизнесийг маань дэмжиж байсан учир надад мөнгө зээлсэн. Би 2 ажилтантай болсон хэдий ч шаардлагатай тоног төхөөрөмжөө худалдаж авч чадаагүй л байна. Фейсбүүк хуудсаар дамжуулан өөрсдийн бүтээгдэхүүнийг сурталчилж эхлээд 4 жил болж байна. Цар тахлын улмаас манай борлуулалт маш муудаж ажилчдынхаа цалинг тавьж чадахгүй бэрхшээлтэй тулгараад байгаа юм. Монгол эсгийгээр хийхгүй урлалын эсгий гээд Хятадаас орж ирдэг эсгийгээр бүтээгдэхүүнээ хийдэг учир түүхий эд маань хомсдоод байгаа.

Одоогоор би өөрийн санхүүгийн мэдлэгийг сайжруулах шаардлагатай байна. Албан бизнес болохыг хүсэх юм бол санхүүгийн тал дээр болон тайлан тооцооны тал дээр хатуу байхыг би ойлгож байгаа. Түүнчлэн албан бизнес эрхлэгчид жижиг зээл авах боломжгүй байдаг гэдгийг ч мөн ойлгож байгаа. Энэ нь МУЗГ-аас зарлах зээлд хамрагдах боломжгүй болж байгаа юм. Тийм учраас би албан бизнес болгох гэж оролдож үзээгүй байна. Албан болох юм бол ажилчид маань нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалыг албан байгууллагаас төлөх боломжтой болно гэдгийг мэдэж байгаа. Албан бизнес болоход гарах өөр нэг асуудал нь маш өндөр түрээсийн төлбөр төлөх явдал юм. Албан бизнес эрхлэгчдэд оффисын түрээс хоёр дахин өндөр болдог тиймээс би албан бизнес эрхлэгч болох гэж яарахгүй байгаа юм. Зээл авахын тулд албан бизнес эрхлэгчид хамгийн багадаа 2 жилийн санхүүгийн тайланг өгөх ёстой болдог. Эдгээр шалтгаануудын улмаас би албан бус бизнес эрхлэгчээрээ үлдэх сонирхолтой байгаа. Ихэнх улсаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд нь жижиг болон дунд үйлдвэрлэл рүү чиглэсэн байдаг.

КОВИД-19-ын сөрөг нөлөөг хэрхэн давж гарч ирэхээс шалтгаалан бид албан бизнес болох эсэхээ шийдэх болно. Одоогийн нөхцөл байдалд бол би ердөө борлуулалтаа нэмэх тал дээр л ажиллаж байна. Би цэцэрлэгийн багш нарт хүүхдүүддээ би эсгий бүтээгдэхүүнийг худалдаж авах юм бол онлайн сургалт зохион байгуулахад нь туслах талаар санал болгож байгаа. Учир нь манай эсгий тоглоомууд боловсролд ч мөн нөлөөлдөг гэдгийг би ойлгож байгаа. Манай ээж болон найзууд өөрсдийн хүрээллээрээ дамжуулан миний бүтээгдэхүүнүүдийг борлуулахад тусалж байгаа. Нөгөө талаар КОВИД-19-ын нөхцөл байдал биднийг хувцастай тоглоом хийх шинэ боломжийг олгосон. Хил хаалттай учраас Хятад улсаас орж ирдэг хуванцар тоглоомууд мөн хязгаарлагдсан. Энэхүү сүлжээгээр дамжуулж бид нэг байгууллагад 200 ширхэг хувцастай тоглоом бэлдэж өгөхөөр болсон. Энэхүү боломж нь миний нүдийг нээж бизнесээ өргөжүүлэх хүчийг өгсөн юм.

Санхүүгийн нөөцийн хувьд миний хоёр ажилтан энэхүү бизнест мөн өөрсдийн хүүхдийн мөнгийг нэмэрлэсэн. Бид нэг нэгэндээ итгэж хамтран шийдвэрээ гаргах ёстой. Манай ээж цэцэрлэгийн багш байсан учир мөн биднийг шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлдэг. Ойрын ирээдүйд бидэнд өөрсдийн бүтээгдэхүүнээ боловсролын нөлөө бүхий төрлөөр өргөжүүлэх санаа байгаа. Одоогоор бидэнд түүхий эдээ энэ хүнд нөхцөл байдалд татан авах санхүүгийн дэмжлэг л хэрэгтэй байна.

Хэдийгээр Монголын жендерийн хэвшмэл ойлголтын дагуу гэр бүлийн үүрэг хариуцлагыг өрхийн эмэгтэй, эрэгтэй гишүүдэд тэгш бусаар хуваадаг боловч, эрх мэдлийн хуваарилалт нь харьцангуй тэгш байдаг гэж судалгаанд оролцогчид үзэж байна. Чанарын судалгаагаар судалгаанд оролцогчдоос тэд гэр бүл болон бизнестээ зарцуулах цагаа хэрхэн тэнцвэртэй хуваарилдаг талаар асуухад гэр орны ажил өрхийн эрэгтэй болон эмэгтэй гишүүдийн хооронд тэнцүү биш хуваарилагддаг гэж хариулсан байна. Эрэгтэй бизнес эрхлэгчдийн хувьд гэр бүлийн үүрэг хариуцлага нь бизнес эрхлэхэд төдийлөн нөлөө үзүүлдэггүй, учир нь тэдний гэр бүлийн хүн болон хамтрагч энэ асуудлыг хариуцдаг гэж хариулжээ (Жишээ 13-ыг харна уу). Эмэгтэй бизнес эрхлэгчдийн хувьд, хамтрагчид нь гэр орны ажилд төдийлөн тусалдаггүй гэж хариулсан байгаа нь гэр бүлийн үүрэг хариуцлагад эрэгтэйчүүд тэгш оролцох хандлага бага байгааг илэрхийлж байна.

***Жишээ 12: Эрэгтэй бизнес эрхлэгч***

*Эхнэр маань хүүхдээ хараад гэртээ байгаа болохоор тэр талаар асуудал байхгүй. 6 сард эхнэр маань ажилд орохоор хүүхдээ хэнд харуулах талаар одоогоор бодсон юм алга. Ажил маань цаашдаа үргэлжлээд явбал эхнэрээ ажил хийлгэх шаардлага байхгүй. КОВИД-19-ын хязгаарлалтаас шалтгаалан ажил хийх шаардлага гарч ирж байна. Тухайн үед бид ажил дээрээ байх үед хүүхдээ хүнд харуулах шаардлага гарах байх.*

*Бизнес эрхлэгч – эрэгтэй –*
*Дорнод аймаг – мужаан*

**Бизнес эрхлэгч эмэгтэйчүүд хүүхдээ болон ахмад настныг (гэр бүлийн бусад тусгай хэрэгцээт гишүүдийг гэх мэт) асрах “давхар” үүрэг хариуцлагыг хүлээдэг байна.** Ойролцоогоор таван эмэгтэй тутмын нэг нь буюу 17 хувь нь гэр бүлийн аль нэг гишүүнээ гэртээ байнга асрах шаардлагатай байна. Үүнд, гэр бүлийн ахмад настан, бага насны хүүхэд, болон хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнийг оруулж болно. Энэхүү “давхар” хариуцлага нь эмэгтэйчүүд уян хатан ажлын цагтай, гэр бүлдээ цагаа зарцуулах илүү боломжийг олгодог “хувийн бизнес” эхлүүлэх нийтлэг шалтгааны нэг болж байна. Харин бизнес эрхлэгч эрчүүд илүү өөрийн зорилго, мөрөөдөл эсвэл ирээдүйд олох эдийн засгийн ашиг сонирхолд тулгуурлаж бизнесээ эхэлсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй эсвэл эрүүл мэндийн шалтгаантай бизнес эрхлэгч эмэгтэйчүүд гэнэтийн эрсдэлд илүү өртөмтгий байна. Ялангуяа, судалгаанд оролцогчдын 14 хувь нь хэвийн амьдралаар амьдрахад нь саад болохуйц хөгжлийн бэрхшээлтэй зэргээс үүдэн бизнесээ бүр мөсөн хаасан тохиолдол нь илүү өндөр байна. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хувьд ажил эрхлэх цор ганц арга бол хувийн бизнес эрхлэх гэж хариулсан байна. Яагаад гэвэл ажлын газрууд ихэвчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилд авахаас татгалздаг юм байна. Бизнес эрхлэх нь ажил болон амьдралын тэнцвэрийг бий болгохоос гадна, зарим хүмүүсийн хувьд санхүүгийн хувьд биеэ даах боломж олгодог гэв.

Зураг 13: Судалгаа авах үе дэх бизнесийн нөхцөл байдал, гэрлэлтийн байдлаар



**КОВИД-19 цар тахлын үед хөгжлийн бэрхшээлтэй болон гэр бүлгүй эмэгтэйчүүд илүү эмзэг нөхцөл байдалд байсан ба бизнес нь түр эсвэл бүрэн хаагдах нөхцөл байдалтай тулгарчээ.** Судалгаанд оролцсон нийт эмэгтэйчүүдийн 75 хувь нь гэрлэсэн буюу хамтрагчтай, 25 хувь нь өрх толгойлсон буюу ганц бие эмэгтэйчүүд байна. Ганц бие эмэгтэйчүүд ихэвчлэн 15-аас дээш насны эсвэл хүүхэдгүй байна.

Дээрх Зураг 13-д үзүүлсэнчлэн гэрлэсэн эмэгтэйчүүдтэй (18 хувь) харьцуулахад гэрлээгүй эмэгтэйчүүдийн бараг гуравны нэг (32 хувь) нь бизнесээ бүрэн хаасан байна. Түүнчлэн нөхөр эсвэл хамтрагч нь тусдаа орлого олдог эмэгтэйчүүд бизнесээ тулхүү түр хугацаагаар хаасан байна. Мөн гэр бүлтэй эмэгтэйчүүдэд гэр орны үүрэг хариуцлага байдаг тул, түр хугацаагаар бизнесээ хаахаас өөр аргагүй болсон байна. Бизнес нь бүрэн хаагдсан тохиолдолд гэрлэсэн эмэгтэйчүүдийг бодвол гэрлээгүй эмэгтэйчүүдэд илүү хүнд тусаж “бэрхшээл” нэмэгдсэн байна. Энэ нь гэр бүлийн гишүүдийн зүгээс үзүүлэх дэмжлэг, санхүүгийн туслалцаа байхгүйтэй тодорхой хэмжээнд холбоотой.

***Жишээ 13: Өрх толгойлсон эмэгтэй***

*Орлого багасаж, орлогогүй болсон. Оройдоо хүүхдүүддээ хоол ундны юм авч явдаг байсан чадахаа больсон. Захиалагч нар багассан. Үйлчлүүлж байсан хүмүүс цөөрсөн. Байнгын үйлчлүүлэгчээс өөр үйлчлүүлэгчгүй болсон. Хувцасны засвар үйлчилгээний ажил их байсан бол одоо байхгүй болсон. Өдийд цагаан сарын болон шинэ жилийн захиалгад дарагдсан байдаг байсан бол одоо ямар ч захиалга байхгүй байна.*

*Бизнес эрхлэгч– эмэгтэй –*
*Дорнод аймаг - оёдол*





# 3 ЭДИЙН ЗАСАГ БОЛОН НИЙГМИЙН КАПИТАЛЫН ҮНЭЛГЭЭ

Эдийн засгийн капиталд хүмүүсийн биет, санхүүгийн болон үйлдвэрлэлийн хөрөнгийг авч үзэх ба үүнд хүмүүсийн цалинтай ажил эрхэлдэг, хадгаламж, даатгалтай, нөөцөө ашиглаж, хянах боломжтой эсэхийг багтаана. Нийгмийн капиталд харилцан ашигтай дэмжлэг үзүүлдэг, нэг сонирхол туршлагаараа нэгдэж чадсан хүмүүсийн хүрээлэл орох ба хүмүүс хоорондын ялгааг бууруулж, өөр өөр эрх мэдэл, нийгэмд үзүүлэх нөлөө бүхий хүмүүс хоорондын харилцаа багтана. Энэхүү хэсэгт КОВИД-19 цар тахлын улмаас бизнесийн нөхцөл, үйл ажиллагаатай холбоотойгоор бий болсон нийгэм эдийн засгийн онцгой нөхцөл байдлыг задалж үзнэ. Диаграммд 3-т капиталын үнэлгээний үр дүнг тоймлон харуулав.

Диаграмм 3: Капиталын үнэлгээний үр дүнгүүд




Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн 65 хувь нь бизнесээ анх эхлэхдээ ганцаараа эхэлж байсан бол 35 хувь нь бусад хүмүүстэй хамтран эхлүүлж байжээ. Харин одоо эдгээр бизнес эрхлэгчдийн 73 хувь нь бизнесээ дангаараа эзэмшиж байгаа бол 27 хувь нь хамтарсан өмчлөлөөр үйл ажиллагаагаа явуулж байна. Бизнесийн гол салбараар харьцуулан үзвэл, хөдөө аж ахуйн салбарт бизнес эрхэлж буй эмэгтэйчүүд (52 хувь) түлхүү хамтарсан бизнес эрхэлж байгаа бол, жижиглэн худалдаа (85 хувь), үйлдвэрлэл (80 хувь), үйлчилгээний (80 хувь) салбарт ажиллаж буй эмэгтэйчүүд бизнесээ дангаараа эзэмшиж байна.

Зураг 14: Бизнесийн өмчлөлийн хэлбэр




# 3.1 Эдийн засгийн капитал

### 3.1.1 КОВИД-19-ын өмнөх капитал

**Судалгаанаас харахад, КОВИД-19 цар тахал дэгдэхээс өмнө бизнес эрхлэгч эмэгтэйчүүд бараа бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ болон улирлын хэлбэлзлийг мэдэрч, тогтмол үйлчлүүлэгчдээ хэрхэн татах аргаа сайн мэддэг байсан байна.** КОВИД-19 цар тахал болохоос өмнө олон бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн хувьд түүхий эд худалдан авах хангамжийн сүлжээ, үйлчлүүлэгчид, худалдагчид, борлуулагчдын үйл ажиллагаа нь найдвартай тогтмол байсан гэв. Жишээлбэл, бизнес эрхлэгч эмэгтэйчүүд захиалга, эсвэл улирлын чанартай эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үйлдвэрлэлээ эрхэлдэг байсан байна.

**Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн хувьд санхүүгийн эх үүсвэр дутмагаас бизнесээ өргөжүүлж албажуулахгүй байгаа бол эрэгтэй бизнес эрхлэгчдийн хувьд энэ нь төдийлөн бэрхшээл болдоггүй байна. Хөрөнгийн эх үүсвэр дутмагаас үүдэлтэй** санхүүгийн тогтворгүй байдал нь КОВИД-19 цар тахлаас үл хамааран, өмнө нь ч олон бизнес эрхлэгчдэд тулгарч байсан бэрхшээл юм. Чанарын судалгаанаас харахад бизнес эрхлэгч эмэгтэйчүүд ихэвчлэн санхүүгийн хувьд тогтворгүй байна.

**Санхүүгийн дэмжлэг нь эмэгтэй эздтэй бизнесийн гол дэмжлэг болж байжээ. Бизнес эрхлэгч эмэгтэйчүүд бизнесээ авч үлдэхэд чухал гурван арга хэмжээг тодорхойлсон байна.** Тухайн арга хэмжээ нь техникийн шийдэл гэхээс илүү санхүүгийн хүчин чадалтай холбоотой байв. Үүнд: санхүүгийн эх үүсвэрийн хүртээмж (77 хувь), түрээсийн хөнгөлөлт (40 хувь) болон уян хатан зээлийн нөхцөл (39 хувь) багтсан байна. Харин техникийн хүчин чадлаа нэмэгдүүлэх арга хэмжээнд бизнесийн стратеги боловсруулах (21 хувь), технологийн шинэчлэл нэвтрүүлэх (18 хувь) болон зах зээлд нэвтрэх (17 хувь) гэж хариулжээ.

**Бизнес эрхлэгч эмэгтэйчүүд ихэвчлэн хувийн болон өрхийн хадгаламж, өрхийн орлого, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн эх үүсвэрээр бизнесээ эхлүүлдэг.** Судалгаанд оролцогчдоос бизнесээ эхлүүлэхдээ, мөн КОВИД-19 цар тахлаас өмнө бизнесээ тогтвортой явуулахын тулд ямар албан болон албан бус санхүүгийн эх үүсвэр ашиглаж байсан талаар тодруулсан. Тоон судалгааны үр дүнд (Хүснэгт 2) оролцогч эмэгтэйчүүдийн 41 хувь нь санхүүгийн байгууллагуудаас (Банк, ББСБ, санхүүгийн хоршоо, хувь хүн) зээл авсан бол, 42 хувь нь хамаатан садан/гэр бүлээсээ (эсвэл тэдний хувийн хадгаламжийг ашиглан) дэмжлэг авсан болохыг харуулж байна. Оролцогчдын дөнгөж 21 хувь нь хувийн хадгаламж ашиглан бизнесээ эхлүүлсэн. Өөрөөр хэлбэл эмэгтэйчүүдийн бараг аравны найм буюу 79 хувь нь бизнесээ эхлүүлэхдээ гадны санхүүгийн эх үүсвэр ашигласан гэсэн үг юм. Төрийн болон төрийн бус байгууллагуудаас олгосон бусад санхүүгийн эх үүсвэрүүд ач холбогдолгүй байсан нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Зураг 15: Бизнесээ тогтвортой явуулахад авах чухал арга хэмжээ




Хүснэгт 2: Эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүгийн эх үүсвэр; бизнесээ эхлүүлэхдээ болон үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад (хувиар)

| Санхүүгийн эх үүсвэрүүд | Бизнесээ анх эхлүүлэхдээ | Бизнесийн үйл ажиллагааг тогтвортой явуулахад |
|---|---|---|
| Арилжааны банкнаас зээл авсан | 29 | 41 |
| Банк бус санхүүгийн байгууллагаас зээл авсан | 8 | 11 |
| Хадгаламж зээлийн хоршоо/Нөхөрлөлөөс зээл авсан | 3 | 4 |
| “Нэг өдрийн зээл” болон “Цалин буухаар төлдөг зээл” гэх мэт албан бус санхүүгийн эх үүсвэрээс зээл авсан | 1 | 4 |
| Хамаатан садан/гэр бүл/найз нөхдөөс зээл авсан | 12 | 21 |
| Хувийн хадгаламжаа зарцуулсан | 21 | 23 |
| Хамтран амьдрагч/гэр бүлийн гишүүдийн хадгаламжийг зарцуулсан | 9 | 13 |
| Хувийн эд хөрөнгөө зарсан | 4 | 6 |
| Бизнесийн эд хөрөнгөө зарсан | 2 | 2 |
| ЖДҮ хөгжүүлэх сангийн дэмжлэг | 7 | 7 |
| Олон улсын байгууллага эсвэл төслүүдийн буцалтгүй тусламж, дэмжлэг | 4 | 3 |
| Ломбард, барьцаат зээл | 5 | 14 |

**Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн хувийн хадгаламж болон бусад санхүүгийн эх үүсвэр нь бизнесийн санхүүгийн эх үүсвэр болох хэмжээнд хүрэхгүй байгаа тул бизнесээ тогтвортой байлгахын тулд гадны санхүүгийн эх үүсвэрээс хамааралтай болж байна.** Тоон судалгааны үр дүнгээс харахад судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн 60 хувь нь санхүүгийн байгууллагуудаас зээл авч байсан бол тэдний 57 хувь нь гэр бүлээсээ санхүүгийн дэмжлэг авч байсан байна. Гадны санхүүгийн эх үүсвэрээс зээл авсан эмэгтэйчүүдийн ээлэх хувь нь бизнес эрхэлж эхэлснээс хойш мэдэгдэхүйц өссөн бол, хувийн хадгаламжаасаа мөнгө татах хэмжээнд нь огт өөрчлөлт ороогүй байна. Энэ нь бизнес эрхэлдэг эмэгтэйчүүд бизнесээ үргэлжлүүлэн явуулахын тулд гадны эх үүсвэрээс илүү их хамааралтай болж байгааг харуулж байна.

***Жишээ 14: Барьцаа хөрөнгө байхгүйгээс зээл авах боломжгүй.***

*Санхүү дээр гацаад байна. Хэдий өөрчлөлт хийгээд яваад байгаа ч гэсэн өөрөө бүх зүйлээ хийдэг учир материал, нөөц бага хийж чадахгүй байна. Бүтэн өөрчлөлт хийх гэхээр нөөц дутаад хийж чадахгүй байна. Миний банк бусаас авсан зээл дуусаагүй байгаа. Зээлийн хүү нь нэлээн өндөр байдаг. Эргээд зээл авах гэхээр барьцаа хөрөнгө байхгүй, нэмэлт зээл авах гэхээр одоо ийм байдалтай байгаа учир нэмж зээл авч чадахгүй байдалтай байна. Жижиг, дунд эсвэл бага хүүтэй зээл гарвал энэ байдлаасаа гарах боломж байна.*

*Бизнес эрхлэгч –*
*Улаанбаатар хот - оёдол*

**Судалгаанд хамрагдагчдын талаас илүү буюу 58 хувь нь бизнесийн зээл авсан байна.** Эмэгтэй бизнес эрхлэгчдийн авсан зээлийн дундаж хэмжээ 7,307,547 төгрөг ба дунджаар 24 сарын хугацаатайгаар зээл авч байжээ.

Зураг 16: Зээл авсан байдал




**Барьцаа хөрөнгө дутагдалтай болон хатуу шаардлагуудыг тавьдаг гэдгээс шалтгаалан эмэгтэй бизнес эрхлэгчид албан санхүүгийн эх үүсвэрээс хүртэж чадахгүй байна.** Судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь зээлийн хүү өндөр байна гэж үзсэн. Мөн банкнаас тавьдаг бусад шаардлагууд болох барьцаа хөрөнгө, хатуу нөхцөл, төлөлтийн хугацаа хэтэрхий богино байдаг зэрэг бэрхшээлүүдийг дурдаж байв.

**Барьцаа хөрөнгөтэй холбоотой асуудлыг шийдэхийн тулд бизнес эрхлэгч эмэгтэйчүүд "тэтгэврийн зээл", "өрхийн зээл", болон/эсвэл "цалингийн зээлийг" санхүүгийн эх үүсвэр болгон ашиглаж байна.** Кейс судалгаа болон чиглүүлэгтэй ярилцлагын үр дүнгээс харахад судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчид зээл авахад хамгийн их тулгардаг бэрхшээлээр өндөр хүү болон барьцаа хөрөнгийг нэрлэсэн байна. Чанарын судалгаанд оролцсон эрэгтэй болон эмэгтэй бизнес эрхлэгчдийг харьцуулж харахад, санхүүгийн дэмжлэг авахад тулгардаг бэрхшээл нь бараг ялгаагүй байна. Судалгаанд оролцогч бизнес эрхлэгч эмэгтэйчүүд нэр дээрээ зээл авах боломжгүй бол гэр бүлийн гишүүний нэр дээр зээл авдаг, эсвэл "цалингийн зээл" болон "тэтгэврийн зээл" түлхүү авч байгаа нь харагдаж байна. Сонирхолтой нь эмэгтэйчүүдтэй харьцуулахад бизнес эрхлэгч эрэгтэйчүүдэд санхүүгийн байгууллагуудаас зээл авахдаа барьцаа хөрөнгөний асуудалтай тулгардаггүй байна.

Зураг 17: Зээл авахад тулгарсан бэрхшээл




***Жишээ 15: Зээл авахад тулгарсан бэрхшээл***

*Зээл авахад барьцаа хөрөнгө шаардлагатай боловч надад барьцаа хөрөнгө байхгүй. Би жижиг төсөл бичээд, төслөөрөө зээл авсан. 2 жилийн дараа 10 сая төгрөгийн зээл авъя гэхэд барьцаа хөрөнгөний асуудал үүссэн. Зээл авахад тулгардаг гол хүндрэл нь барьцаа хөрөнгө, хүү өндөртэй, хугацаа багатай байдаг.*

*Бизнес эрхлэгч – эмэгтэй – Чингэлтэй дүүрэг – хувцасны салон*

**Ганц бие, өрх толгойлсон болон хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд барьцаа хөрөнгийн асуудалтай илүү тулгарч байна.** Санхүүгийн боломжоос гадна, барьцаа хөрөнгийн асуудлыг тодруулан авч үзэхэд, нийт эмэгтэйчүүдийн 53 хувь нь барьцаа хөрөнгөгүй гэж хариулсан байна. Эмэгтэйчүүдийн бүлгээр нь харьцуулан үзвэл, ганц бие өрх толгойлсон эмэгтэйчүүд (70 хувь) болон хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд (68 хувь) барьцаа хөрөнгийн холбоотой асуудал илүү тулгарч байна.

**Салбарын онцлог байдлаас шалтгаалан жижиглэн, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд илүү бэрхшээл тулгарч байгаа** бол хөдөө аж ахуйн салбарынханд арай бага тулгарч байна. Өмнөх бүлгүүдэд дурдсанчлан, хөдөө ахуйн салбарт бизнес эрхэлдэг эмэгтэйчүүд түлхүү бизнесийн хамтарсан өмчлөлтэй, бусадтай хоршоолон

Зураг 18: Барьцаа хөрөнгөтэй холбоотой бэрхшээл, гэрлэлтийн байдлаар




Зураг 19: Барьцаа хөрөнгөтэй холбоотой бэрхшээл, хөгжлийн бэрхшээлтэй эсэхээр




Зураг 20: Барьцаа хөрөнгөтэй холбоотой бэрхшээл, салбараар




Зураг 21: Барьцаа хөрөнгөтэй холбоотой бэрхшээл, байршлаар




бизнес эрхэлдэг, төдийгүй нөхөр/хамтрагчаасаа илүү орлого олдог гэж хариулсан хувь өндөр байсан.

**Хөдөө орон нутагт бизнес эрхэлдэг эмэгтэйчүүдэд барьцаа хөрөнгө шаардагддаггүй, мөн санхүүгийн бусад сонголтууд байсан тул барьцаа хөрөнгөтэй холбоотой бэрхшээлтэй тулгарах нь харьцангуй бага байв.** Тоон судалгаанаас харахад хот суурин газрын бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн 63 хувь нь барьцаа хөрөнгө байхгүйгээс бэрхшээлтэй тулгарч байсан бол хөдөө орон нутгийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн дөнгөж 45хувь нь ижил хариулт өгчээ. Мөн хөдөө орон нутгийн эмэгтэйчүүд ихэвчлэн хөдөө аж ахуйн салбарт бизнес эрхэлдэг тул, тухайн асуудал нь нэг их бэрхшээл болоогүй гэнэ.

### 3.1.2 КОВИД-19-ын үеийн аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө ба хөрөнгийн менежмент

Судалгааны үр дүнгээс харахад бизнес эрхлэгчид зээлээ хугацаанд нь төлж, эсвэл шинээр зээл авч чадахгүйн улмаас санхүүгийн байгууллагуудаас байнгын хараат болж, капиталаа авч үлдэх боломжгүй болж байна. КОВИД-19-ын өмнөх нөхцөл байдалтай адилаар одоогийн санхүүгийн тогтворгүй байдал нь санхүүгийн эх үүсвэр хүртээмжгүй улмаас үүдэлтэй бөгөөд энэ нь эмэгтэй, эрэгтэй аль ч бизнес эрхлэгчдэд цар тахлын үеэр илүү мэдрэгдэж байна. **Эмэгтэй эрэгтэй бизнес эрхлэгчид хоёулаа зарим тохиолдолд өөрийн бизнесийн үйл ажиллагаа түр (эсвэл бүрэн) зогсоож,**

**хаажээ.** Цөөн тохиолдолд зарим бизнес эрхлэгчид ажилтнуудын цалинг багасгаж, эсвэл ажилчдаа ажлаас чөлөөлж, халсан байна. Түүнчлэн эрэгтэй болон эмэгтэй бизнес эрхлэгчдийн бизнесийн борлуулалт эрс буурсан хэдий ч түрээсээ үргэлжлүүлэн төлөх шаардлага тулгарчээ. Жишээлбэл, бизнес эрхлэгч эмэгтэйчүүд зээлийн эргэн төлөлт болон лангууны түрээсээ төлөх шаардлагатай болсон. Эрэгтэй бизнес эрхлэгчид харин өөрийн эд хөрөнгөө царцааж, бизнесийн үйл ажиллагаа явуулдаг газраа идэвхгүй болгож буй тохиолдол түгээмэл байна. Тухайлбал, бизнес эрхлэгчид худалдааны төвүүд хаагдсанаас шалтгаалан лангуунуудаа ашиглаж чадахгүй орхисон юм.

Зээлийн эргэн төлөлтийг хойшлуулсан шийдлээс бизнес эрхлэгч болгон хүртэж чадаагүй. Чанарын судалгаанаас гарч ирсэн зээлтэй холбоотой сонирхолтой үр дүнг харвал КОВИД-19 цар тахлын үед Монгол банкнаас “КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнээс үүдэн зээлийн эргэн төлөлтөө хийхэд хүндрэл учирч буй зээлдэгчид нь зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрөө түр хугацаагаар эргүүлэн төлөх боломжгүй тохиолдолд тухайн зээлдэгчийн зээлийн ангиллыг хэвээр үлдээж, Зээлийн мэдээллийн санд ангилал бууруулж мэдээлэхгүй байх боломжийг бүрдүүлж байна” гэх зохицуулалтыг гаргасан хэдий ч нас болон эргэн төлөх чадвартай холбоотой байдлаас нэг ч оролцогч зохицуулалтын үр шимтийг хүртэж чадаагүй гэжээ. Өндөр настай бизнес эрхлэгчдийн дунд иймэрхүү тохиолдол хэр их гарсныг хэлэхэд бэрх ч, ихэвчлэн эрт тэтгэврээ тогтоолгодог бизнес эрхлэгч эмэгтэйчүүд иймэрхүү асуудалд түлхүү өртдөг байх магадлалтай.

**Цар тахлын улмаас бизнес эрхлэгч эмэгтэйчүүд нөхцөл байдлыг даван туулахын тулд өөрийн хадгаламжаа ашиглаж, эд хөрөнгөө зарж эхэлсэн байна.** Судалгааны үр дүнгээс харахад тэдний бараг тал буюу 49 хувь нь цар тахлын үеийг даван туулахын тулд өөрийн хадгаламжаа ашигласан мөн/эсвэл өөрийн болон бизнесийн эд хөрөнгөө зарсан гэж хариулсан байна.

***Жишээ 17: Зээл авахад тулгарсан бэрхшээл***

*3 өрөө байр авч салоноо өргөжүүлэхийн тулд зээл авч байсан. Гэвч миний зээл царцаагүй, яагаад царцаагүй вэ гэхээр тэтгэвэрт гартлаа зээл авсан учраас зээл царцаахаар дахиж гэрээ зурна тэгэхээр миний нас дуусаж байгаа гэсэн үг тэгэхээр шууд зээл царцаахгүй гэсэн. Одоо орон сууцаа зарна гэж бодож байгаа 40,50 сая төгрөгийн зээл үлдчихсэн тэгэхээр түүнийг хаахын тулд зээлээ хаахаас өөр арга байхгүй байна.*

*Бизнес эрхлэгч – эмэгтэй – Увс аймаг – газар тариалан*

Эдгээрийг өөрийн санхүүгийн нөөцөө болгож ашигласан гэх хариулт өгсөн эмэгтэйчүүдийн хувь цар тахлын өмнө эдгээрийг ашигласан гэх хариулт өгсөн эмэгтэйчүүдээс хамаагүй өндөр хувьтай байгаа нь, бизнесээ авч үлдэхийн тулд хэрхэн санхүүгийн эх үүсвэрээ өөрчилж байгааг харуулж байна.

Хөрөнгөө зарж, хадгаламжаа ашигласан гэх хариулт өгсөн эмэгтэйчүүдийн хувь цар тахлын өмнө эдгээрийг ашигласан гэх хариулт өгсөн эмэгтэйчүүдээс хамаагүй өндөр хувьтай байна. Яаран сандран эд хөрөнгөө ломбардад зарсан гэх баримтаас эмэгтэй бизнес эрхлэгчид цар тахлын үед мөнгө санхүүгийн хувьд их тогтворгүй, хэцүү байдалд байсан гэдгийг харуулж байна. Бизнес эрхлэгчдийн нас, боловсролын байдал, бизнес эрхэлдэг байршлаас үл хамааран бизнес эрхлэгч эмэгтэйчүүд КОВИД-19 цар тахлыг даван туулахын тулд ижил санхүүгийн эх үүсвэрийг ашиглаж байна. Чанарын судалгааны үеэр эрчүүд цар тахлын үед бизнесээ тогтвортой явуулахын тулд хувийн хадгаламжаа ашигладаггүй, найддаггүй гэсэн үр дүн гарчээ.

Хүснэгт 3: Эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүгийн нөөц (хувиар)

| Санхүүгийн эх үүсвэрүүд | Бизнесээ анх эхлүүлэхдээ | Бизнесийн үйл ажиллагаар тогтвортой явуулахад | КОВИД-ын хориг арга хэмжээнүүд зогссоны дараа үйл ажиллагаагаа сэргээх |
|---|---|---|---|
| Арилжааны банкнаас зээл авсан | 29 | 41 | 26 |
| Банк бус санхүүгийн байгууллагаас зээл авсан | 8 | 11 | 7 |
| Хадгаламж зээлийн хоршоо/Нөхөрлөлөөс зээл авсан | 3 | 4 | 4 |
| “Нэг өдрийн зээл” болон “Цалин буухаар төлдөг зээл” гэх мэт албан бус санхүүгийн эх үүсвэрээс зээл авсан | 1 | 4 | 2 |
| Хамаатан садан/гэр бүл/найз нөхдөөс зээл авсан | 12 | 21 | 16 |
| Хувийн хадгаламжаа зарцуулсан | 21 | 23 | 28 |
| Хамтран амьдрагч/гэр бүлийн гишүүдийн хадгаламжийг зарцуулсан | 9 | 13 | 8 |
| Хувийн эд хөрөнгөө зарсан | 4 | 6 | 10 |
| Бизнесийн эд хөрөнгөө зарсан | 2 | 2 | 7 |
| ЖДҮ хөгжүүлэх сангийн дэмжлэг | 7 | 7 | 3 |
| Олон улсын байгууллага эсвэл төслүүдийн буцалтгүй тусламж, дэмжлэг | 4 | 3 | 1 |
| Ломбард, барьцаат зээл | 5 | 14 | 5 |

***Жишээ 17: Хадгаламжаа ашиглан, ломбардад эд зүйлээ тавьсан.***

*Бизнесээ хадгалж, хамгаалахын тулд хувийн хадгаламж, нөөцөө ашиглах шаардлага гарсан. Өөрийн хадгаламжаа ашиглаж, утас зэргээ зарсан. Нөхрийн хадгаламжаараа зээлээ төлсөн. Одоогоор нөхрийн ажил зогсчихсон байгаа болохоор би өөрийнхөө ажлыг хийж чадаж байна. Өмнө нь ажлаа бүр зогсоочихсон байсан бол одоо нөхөр маань хүүхдүүдээ хараад би ажлаа хийж байгаа. Хадам ээжийнхээ ээмэг бөгжийг ломбардад тавиад авч байсан.*

*Бизнес эрхлэгч – эмэгтэй – Улаанбаатар - оёдол*

***Жишээ 18: Эд хөрөнгөө зарсан мөн хадгаламжаа ашигласан.***

*Хувийн 2 машиныхаа нэгийг нь зарсан дээрээс нь хүүхдийнхээ нэр дээр байсан хадгаламжаа авсан, гэр бүлийн хүнтэйгээ хамтарч шийдвэрээ гаргасан.*

*Бизнес эрхлэгч – эрэгтэй – Сэлэнгэ аймаг - худалдаа*

**Гэр бүлгүй эмэгтэйчүүд КОВИД-19-ын үеэр тулгарсан бэрхшээлийг даван туулахын тулд хадгаламжаа ашиглах, хөрөнгөө зарах байдал нь нөхөртөө найдах боломжтой буюу гэр бүлтэй эмэгтэйчүүдтэй харьцуулахад илүү байна.** Гэр бүлтэй эмэгтэйчүүдийн тал буюу 49 хувь нь өөрийн хадгаламжаа ашиглаж, гэр бүлийн болон бизнесийн эд хөрөнгөө зарсан бол, ганц бие, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн 67 хувь нь эдгээр эх үүсвэрээ зарцуулж, цар тахлыг даван туулах оролдлого хийсэн байна.

## 3.2 Нийгмийн капитал

Бизнес эрхлэгчдийн хүлээж авдаг хамгийн ердийн дэмжлэг бол гэр бүл (бусад хамаатан садан) болон найз нөхдийн харилцан үр ашигтай дэмжлэг юм. Судалгааны үр дүнгээс харахад **бизнес эрхлэгчдийн нийгмийн капитал нь гэр бүл, ураг төрлийн холбоо болон ойр дотнын найз нөхөдтэйгөө харьцах харьцаагаар илэрхийлэгдэж байна.** Тэдний  нийгмийн капитал гэж үзсэн гэр бүл, ураг төрлийн холбоо, найз нөхөд нь өдөр тутмынх нь амьдралд илүү дэмжлэг болж байгаа ч бизнесийн үйл ажиллагаанд харьцангүй бага нөлөө үзүүлж байна. Энэ нь ялангуяа бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн дунд нийтлэг байна, тэд гэр бүлийн гишүүд, ойр дотнын найз нөхдөөс цааш өөр хүрээлэлд орох нь ховор байна. Тиймээс, бизнес эрхлэгч эмэгтэйчүүд мэргэжлийн бизнесийн салбарын хүрээлэл болон зөвлөх үйлчилгээний талаар мэдлэг дутмаг байна. Харин эрэгтэйчүүд бизнесийн мэргэжлийн салбарын хүрээндээ танил тал, холын хамаатан зэргээсээ дэмжлэг туслалцаа авах нь түгээмэл байна.

Чанарын судалгааны үр дүнгээс харахад зарим **бизнес эрхлэгч эмэгтэйчүүд олон нийтийн хүчин зүйлс буюу найз нөхөд, хамтран ажиллагчид эсвэл хөршүүдийн оролцоо, дэмжлэгийг ихэвчлэн хүлээж авчээ.** Тухайлбал, хамтран ажиллагчид эсвэл хажуу лангуунд нь бараа бүтээгдэхүүнээ зардаг хүмүүс нь бизнес эрхлэгчдийг гэр бүлийн ажлаа зохицуулж байх үед нь, лангуур нь харж өгөх эсвэл бараа бүтээгдэхүүнийг нь зарж өгөхөд тусалдаг байна. Бизнес эрхлэгч эмэгтэйчүүд бүтээгдэхүүнээ хүргэх шаардлага гарах үед хөрш нь хүүхдийг нь харж өгөх тохиолдлууд гардаг байна. Ийм нийгмийн капитал нь эмэгтэйчүүдийг бизнес эрхлэхэд нь болон цар тахлыг даван туулахад дэмжлэг болсон байна. **Харин бизнес эрхлэгч эрэгтэйчүүд гэр бүлийн хүрээний бус хүмүүсээс буюу бусад бизнес эрхлэгчид, зөвлөх болон менторууд эсвэл найзуудтайгаа өөрийн бизнесийн нөхцөл байдлын талаар туршлагаа солилцох байдлаар зөвлөлдсөн байна.**

**Гэр бүлтэй холбоотой хүлээх үүрэг хариуцлага нь  эмэгтэйчүүдийн бизнест ахиц дэвшил гаргахгүй байгаа тодорхой шалтгаан гэж үзэж болно.** Бизнес эрхлэгч эрэгтэйчүүд мэргэжлийн болон гадны санхүүгийн бус дэмжлэгийг бизнесээ эрхлэх, хөгжүүлэхэд чухал хүчин зүйл гэж үздэг бол эмэгтэйчүүд гэр бүлийн дэмжлэгийг (хүүхэд асрах, гэр бүлийн үүрэг хариуцлагыг хуваалцах) бизнесээ явуулах, хөгжүүлэхэд хэрэгтэй үндсэн тулгуур дэмжлэг гэж үздэг байна.

**Бизнес эрхлэгч эмэгтэйчүүд маш хязгаарлагдмал нийгмийн оролцоотой.** Судалгаанд хамрагдагчдын дийлэнх буюу 79 хувь нь бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн асуудлаарх ямар нэгэн холбоо, хүрээлэлд харьяалалгүй байна. Эндээс таван хүн тутмын нэг нь л ямар нэгэн холбоо, хүрээлэлд нэгдсэнийг харж болно. Тэдний ихэнх нь зөвхөн нэг холбооны үйл ажиллагаанд оролцдог бол арван бизнес эрхлэгч тутмын нэг нь л хоёроос дээш тооны холбоонд гишүүнчлэлтэй байжээ.

Зураг 22: Оролцогчдын гишүүнчлэлийн байдал




Зураг 23: Гишүүнчлэлтэй байгууллагын тоо




Судалгаанд хамрагдсан аль нэг мэргэжлийн, албан болон албан бус холбоонд бүртгэлтэй эмэгтэйчүүдийн хувьд дараах байгууллагуудыг нийтлэг дурджээ (Хүснэгт 4).

Хүснэгт 4: Нийтлэг гишүүнчлэлтэй байгууллагууд

| Салбарын чиглэлийн: | Бизнесийн чиглэлийн: | Эмэгтэйчүүдэд чиглэсэн: |
| --- | --- | --- |
| • Ахуйн Үйлчилгээний Нэгдсэн Холбоо<br>• Үрийн Холбоо<br>• Монгол Ногоо Хөтөлбөр<br>• Монголын Хоол Зүйчдийн Холбоо<br>• Сонгинохайрхан Дүүргийн Гар Урлалын Холбоо | • Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим<br>• Аймгийн Бизнес Эмэгтэйчүүдийн Холбоо<br>• Баялаг Бүтээгчдийн Холбоо<br>• Хадгаламж Зээлийн Хоршоо<br>• Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн Төв<br>• Эмэгтэй Бизнес Эрхлэгчдийн Үндэсний Холбоо | • Эмэгтэйчүүдийн Холбоо<br>• Эмэгтэйчүүдийн Хөгжлийн Төв |

Судалгааны үр дүнгээс харахад, аль нэг холбоонд гишүүнчлэлтэй эсэх нь КОВИД-19 цар тахлын улмаас бизнест гарсан өөрчлөлт, ирээдүйн эрсдэл, цаашдын бизнесийн төлөвт мэдэгдэхүйц нэмэргүй байна. Хэдийгээр судалгаанд оролцсон бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн хувьд үндэсний болон орон нутгийн, бизнесийн болон эмэгтэйчүүдийн гэх мэт олон төрлийн бүлэг, хоршоолол, холбоонд гишүүнчлэлтэй байгаа ч, эдгээр нь бизнесийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, гэнэтийн эрсдэлээс хамгаалах, давагдашгүй нөхцөл байдлыг эрсдэл багатай даван туулахад ямар нэгэн санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэг болж чадахгүй байна. Бид энэ талаар 4.2-р хэсэгт илүү дэлгэрэнгүй үзэх болно.

**Чанарын судалгааны үр дүнгээс харахад эрэгтэйчүүд бизнесээ өргөжүүлэхийн тулд мэргэжлийн хүрээнд зөвлөлддөг бол эмэгтэйчүүдийн хувьд эсрэгээрээ оролцох, хамтран ажиллах, туршлагаа хуваалцах, хүрээллээ өргөтгөх гэх мэт боломж хязгаарлагдмал байна.** Үүний улмаас эмэгтэйчүүд мэдлэг чадвар дээшлүүлэх боломжуудад хамрагдаж чаддаггүй. Харин эрэгтэй бизнес эрхлэгчид мэргэжлийн бизнесийн зөвлөхүүдээс, зөвлөгөө зөвлөмж авдаг. Энэхүү үр дүн нь тайлангийн нийгмийн капитал гэсэн хэсэгт дурдагдсантай адил, эмэгтэйчүүд бизнестэй холбоотой аливаа үйл ажиллагаанд оролцож, хамрагддаггүй өөрөөр

Хүснэгт 5: ЖДҮ-д зориулсан санхүүгийн бус дэмжлэг ( хувиар)

| | Орон нутгийн эрх бүхий байгууллагууд (аймаг, дүүргийн ЗДТГ гэх мэт) Банк бус санхүүгийн байгууллагууд | Банк бус санхүүгийн байгууллагууд | Арилжааны банкууд | Засгийн Газрын байгууллага | Мэргэжлийн холбоод | ТББ | Олон улсын байгууллагууд | ЖДҮ-ийн инкубатор |
| --- | --- | --- | --- | --- | --- | --- | --- | --- |
| Бизнесийн түнш, холбоо сүлжээтэй болох боломжууд | 20 | 5 | 5 | 10 | 10 | 10 | 15 | 15 |
| Туршлагаа хуваалцах боломжууд | 6 | 0 | 2 | 4 | 29 | 10 | 18 | 10 |
| Хамтын ажиллагаа, түншлэлийн харилцаа үүсгэх | 10 | 0 | 0 | 3 | 27 | 10 | 17 | 13 |
| Бодлогын зөвлөгөө, дэмжлэг | 15 | 3 | 0 | 3 | 15 | 12 | 15 | 21 |

хэлбэл аль нэг байгууллагад гишүүнчлэлгүй, мэргэжлийн хүрээлэлд орсон байдал дутмаг байгааг харуулж байна. Мөн гэр бүлийн үүрэг хариуцлагын улмаас эмэгтэйчүүд “нэн шаардлагатай биш” гэж үзсэн албан бус бизнес үйл ажиллагаа, уулзалтуудад оролцож чаддаггүй юм байна.

**Хамгийн ихдээ, гурван эмэгтэйн нэг нь л бизнестэй холбоотой үйл ажиллагаанд хамрагдаж, оролцсон байна.** Доорх хүснэгтээс харахад хүрээллээ тэлэх боломжийг нь гол төлөв төрийн байгууллагаас гаргаж байгаа бол туршлагаа хуваалцах, солилцох, хамтран ажиллах боломжийг мэргэжлийн байгууллагууд олгож байгаа нь харагдаж байна. Мөн ЖДҮ-г дэмжих инкубатор төвүүд ихэвчлэн бодлогын зөвлөгөө, дэмжлэг үзүүлж байна.

**Оролцогчдын бараг тал хувь нь эмэгтэй учраас бизнесийн болон танил талын хүрээ муутай гэдгээ мэдэрсэн байна.** Эмэгтэй бизнес эрхлэгчдийн хувьд, гэр бүлийн байдал эсвэл бизнесийн салбараасаа үл хамааран, бизнесийн сүлжээгээ өргөтгөхөд шаардлагатай бодлогын дэмжлэг эсвэл боломжууд дутмаг байна.

***Жишээ 19: Эрэгтэй бизнес эрхлэгчийн танилын сүлжээгээ бизнестээ ашигласан байдал***

*Манай танил надад Засгийн Газрын шинэ тутам гарч буй шийдвэрийн талаарх мэдээллийг дамжуулан өгч, би түүнтэй нь уялдуулан бизнестэй холбоотой шийдвэрээ гаргаж байсан. Нэн ялангуяа бизнесийн үйл ажиллагаагаа зогсоохгүйгээр түүхий эдээ худалдан авах, хянах боломж олддог.*

*Бизнес эрхлэгч – эрэгтэй –*
*Улаанбаатар – жижиглэн худалдаа*

Зураг 24: Бизнес эрхлэхэд хүйсээс хамааран тулгарч буй бэрхшээл




Бизнесийн сүлжээгээ өргөжүүлэх боломж бизнесээ хамтарч эзэмшдэг эмэгтэйчүүдийн хувьд өндөр байхад дангаараа бизнесээ эзэмшдэг эмэгтэйчүүдийн хувьд хязгаарлагдмал байна. Ялангуяа гэр бүлийн хэн нэгнийг асрах, халамжлах шаардлагатай эмэгтэйчүүдийн хувьд энэхүү боломж даруй 23 хувиар бага байгаа нь анхаарал татаж байна. Чанарын судалгаагаар эрэгтэй бизнес эрхлэгчдэд энэ бэрхшээл тулгардаггүй болох нь тогтоогдсон.

Зураг 25: Танилын холбоо, хүрээллээ өргөтгөх боломж хязгаарлагдмал, бизнесийн эзэмшлийн хэлбэр




Зураг 26: Танилын холбоо, хүрээллээ өргөтгөх боломж хязгаарлагдмал, гэр бүлийнхээ хэн нэгнийг асардаг эсэх




**Кейс #2: "Бид КОВИД-19 цар тахалд маш хүчтэй өртсөн"- Эрэгтэй жижиглэн худалдаа эрхлэгч**

Бид ухаалаг гар утасны сэлбэг, эд анги зарж бизнесээ эхлүүлээд жил орчим болж байна. Ухаалаг утасны дэлгэц маш их эрэлттэй байгаа ч хил хаагдсан тул зарим сэлбэг хэрэгслийг Хятадаас авчрах боломжгүй байна. КОВИД-ийн улмаас хүнсний дэлгүүрүүдээс бусад ихэнх бизнесүүд хаалттай байгаа нь бидэнд хүндээр тусч, бид бизнесээ зогсооход хүрсэн. Дараа нь хадам эгч маань хүнсний дэлгүүрүүд нээлттэй хэвээр байгаа юм чинь гээд өндөг зарах бизнест нь хамтран ажиллахыг санал болгосон. Өнөө үед хүмүүс өндөг, бусад хүнсний бүтээгдэхүүнийг ялангуяа МУЗГ-аас хүүхдийн халамж, тэтгэвэр зэрэг халамжийн тусламж өгөх үед илүү их худалдаж авдаг болсон. Энэ бол КОВИД-ийн үеэр манай борлуулалт нэмэгддэг цорын ганц үе юм. Бид өндөг зарж эхлээд аль хэдийн 7 сар болсон байна.

Шийдвэр гаргах үед бол миний гэр бүл, тэр дундаа миний эхнэр хамгийн гол түшиг тулгуур, миний хамгийн гол зөвлөгч байдаг, бид эгчийн саналыг сонсоод л тэр даруй өндөг зарж эхэлсэн. КОВИД-оос өмнө манай дэлгүүр бага сургуулийн хажууд байрладаг байсан тул гэрэл зургийн мухлаг нээж, хувилах, зарим бичгийн хэрэгслийг зарж бизнесээ өргөжүүлэх хэд хэдэн төлөвлөгөөтэй байсан. Гэхдээ КОВИД-ийн улмаас сургуулиудыг хаасан учир бид үйлчлүүлэгчгүй болсон.

КОВИД-оос өмнө бид банкнаас амжилттай зээл авсан. Шаардлагатай баримт бичгийг бүрдүүлж өгвөл зээл авах нь тийм ч хэцүү биш. Иргэний бүртгэлээр бид хотод бүртгэлгүй хэвээр байгаа тул бусад зээлд хамрагдах гэж оролдоогүй. Эхэндээ бид түрээс, цахилгаан гэх мэт бусад үйлчилгээний төлбөрийг төлөх шаардлагатай байсан тул хэцүү байсан. Бид зарим үйлчлүүлэгчдээ татаж чадсан бөгөөд үнэнч үйлчлүүлэгчидтэй байсан боловч КОВИД-оос болоод одоо манай худалдаа зогссон.

Одоо бид лангуугаа ашиглахгүй байгаа болохоор бүх бараагаа гэртээ авчирсан. Түүнчлэн утасны зарим сэлбэг хэрэгсэл, бусад тоног төхөөрөмж, хуулбарлах машин зэргээ бол хадгалсан байгаа. Түрээсийн талбайг ашиглахгүй байгаа үед түрээс төлөхгүйн тулд мөн хэрэгслүүдээ гэртээ авчирсан. Бидэнд хуримтлагдсан хөрөнгө байхгүй тул КОВИД-ийн хязгаарлалт бидэнд маш хүндээр тусаж байна. Нийгмийн дэмжлэгийн хувьд бид бүх талаар бүх цаг үед дэмжиж ирсэн гэр бүлдээ л найдаж байна даа. Албан ба албан бус бизнесийн ялгааг бид мэдэхгүй. КОВИД-ийн үеэр хүнсний дэлгүүрүүд нээлттэй хэвээр үлдсэн тул бид өндөгний борлуулалтыг эрхлэх болсон юм.



# 4 ЧАДАМЖИЙН ҮНЭЛГЭЭ

**Хүмүүст цаг үеийн сорилт бэрхшээл болон бизнесийн капиталаа удирдан зохицуулахад чадварын асуудал шууд нөлөөлдөг.** Судалгааны үр дүнгээс харахад эмэгтэйчүүдийн өрхөд гүйцэтгэж буй үүрэг, хариуцлага нь, тэдний бизнестэй холбоотой танилын хүрээллээ өргөтгөх, тус болох аливаа арга хэмжээнд ихээхэн нөлөөтэй байна. Судалгааны үр дүнгээс гарсан чадамжийг тодорхойлогч хүчин зүйлсийн зураглалыг Диаграмм 4-д харууллаа.

Диаграмм 4: Чадамжийн үнэлгээний үр дүнгүүд




## 4.1 Эрүүл, аюулгүй байдал

**Цар тахлыг даван туулахад хөшүүрэг болохуйц нэн чухал үзүүлэлт нь сэтгэл санаа өөдрөг, бие махбодын аюулгүй байдал буюу айдасгүй амьдрах боломж юм.** Чанарын судалгааны явцад судалгаанд оролцогчдын ерөнхий дүр зургаас харахад, олонх бизнес эрхлэгч эмэгтэйчүүд аюулгүй, тайван орчинд, өөрсдийн мөрөөдлөө биелүүлж, бизнес эрхэлж байгаа нийтлэг дүр зураг ажиглагдаж байв. Ялангуяа, олонх эмэгтэйчүүдээс бизнесээ эхлүүлэх болсон шалтгааны нь тодруулахад мөрөөдлөө биелүүлэхийн тулд гэсэн хариулт нийтлэг байна.

**Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн гэр бүлийн сайн сайхан байдал нь тэдний бизнесийн орлогоос ихээхэн хамааралтай байна.** Гэрлэсэн эмэгтэйчүүдийн 70-аас дээш хувь нь өрхийн орлогынхоо тал болон түүнээс дээш хувийг бүрдүүлж байна. Бизнесийн салбараар нь харьцуулбал, худалдааны (40 хувь) болон үйлчилгээний салбарын (41 хувь) эмэгтэйчүүдийн олонх нь өөрсдийн нөхөр/хамтран амьдрагчаасаа илүү орлого олдог байна. Харин гар урлалын салбарын олонх (39 хувь) нь нөхөр/хамтран амьдрагчаасаа бага орлоготой байгаа бол хөдөө аж ахуйн салбарын эмэгтэй бизнес эрхлэгчдийн олонх нь (49 хувь) нь ижил орлоготой байна. Байршлаар нь харьцуулбал, орон нутгийн бизнес эрхлэгчдийн 74 хувь нь, хотын бизнес эрхлэгчдийн 62 хувь нь нөхөр/хамтран амьдрагчаасаа илүү эсвэл ойролцоо орлоготой байна. Гэрлэсэн гурван эмэгтэй тутмын нэг нь нөхөр/хамтран амьдрагчаасаа илүү орлого олдог.

Зураг 27: Хэн нь илүү их орлого олдог вэ?




Зураг 28: Бие дааж шийдвэр гаргах боломж




**Эмэгтэйчүүдийн бизнесийг гэр бүлийн зүгээс нь урамшуулж, дэмждэг хандлага давуу байна.** Судалгаанд оролцогч эмэгтэйчүүдийн 90 гаруй хувь нь өөрийн бизнестэй холбоотой шийдвэрийг бие даан гаргадаг бөгөөд гэр бүлийн гишүүд нь бизнесийг нь дэмждэг гэж хариулжээ. Хэдийгээр гэр бүлийн зүгээс дэмждэг боловч, гурван бизнес эрхлэгч эмэгтэйн нэг нь бизнес болон гэр бүлээ халамжлах ажлыг зэрэг гүйцэтгэхэд хүндрэлтэй байдаг гэж хариулжээ. Энэхүү хариулт нь эмэгтэйчүүд ажил, гэр бүлийн үүрэг хариуцлагыг давхар гүйцэтгэсээр байгааг харуулж байна. Чанарын судалгааны үр дүнгээс харахад гэр бүлийн зүгээс үзүүлж байгаа дэмжлэгт КОВИД-19-ын өмнө болон дараа ямар нэгэн өөрчлөлт гараагүй нь харагдаж байлаа.

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн 5 хувь нь бизнесээ эрхлэх явцдаа гэр бүлийн гишүүдийн сөрөг хандлагатай тулгарч байсан байна.

Зураг 29: Гэр бүлийн дэмжлэг




**Тусгай хэрэгцээтэй буюу эрүүл мэндийн улмаас эмзэг нөхцөлд байдаг бизнес эрхлэгч эмэгтэйчүүд гэнэтийн эрсдэлүүдэд өртөмтгий байна.** Тодруулбал, судалгаанд оролцсон нийт эмэгтэйчүүдийн 14 хувь нь хэвийн амьдрах чадварыг нь хязгаарладаг ямар нэгэн хөгжлийн бэрхшээлтэй байгаа бөгөөд эдгээр эмэгтэйчүүдийн дунд бизнес нь бүрэн хаагдсан хувь хэмжээ бусад оролцогчидтой харьцуулахад өндөр байна. Гэхдээ тухайн эмэгтэйчүүдийн хувьд ажил олгогчийн зүгээс ялгаварлан гадуурхалтай ихээхэн нүүр тулдаг тул хувийн бизнес эрхлэх нь ажилтай байх цорын ганц арга ажээ.

Зураг 30: Бизнесийн өнөөгийн байдал, хөгжлийн бэрхшээлээр



***Жишээ 20: Хөгжлийн бэрхшээлтэй бизнес эрхлэгч эмэгтэй***

*Би Улаанбаатар эрдэм дээд сургуулийг төгссөн. Төгсөөд Хаан банканд дөрвөн жил теллер хийж байгаад 2013 онд группт гарсан. Хөгжлийн бэрхшээлтэй гэсэн үг. Группт гараад нэг жилийн дараа анхныхаа хүүхдийг гаргасан. Хүүхдээ хараад гэртээ байх хугацаандаа надад өөрийн гэсэн орлого хэрэгтэй байсан. Youtube -с гар, урлалын бичлэг үзээд хийж эхэлсэн. Анх гоёл чимэглэл хийж эхэлсэн. Тэрийгээ фейсбүүкээрээ борлуулж эхэлсэн. Дараа нь нөхөртэйгөө хамтраад хүүхдийн модон тоглоом хийсэн. Тоглоомоо үйлдвэрлээд яг зарж эхлэхэд КОВИД-19 гарсан. Тийм болохоор орлого муу, зээл авах боломжгүй, дээр нь барьцаа хөрөнгө муу учраас зээл авах гэж оролдоогүй. Зээл авсан ч эргүүлж төлөх боломжгүй учраас ер нь хөөцөлдөж үзээгүй.*

*Бизнес эрхлэгч – эмэгтэй - Улаанбаатар – гар урлал (модон тоглоом)*

**Арван эмэгтэй тутмын нэг нь гэр бүлийн орчинд бие махбодын болон сэтгэл зүйн хувьд тайван бус, аюултай байдалд байна.** Эмэгтэйчүүд гэр бүлийн болон бизнес эрхэлж буй орчиндоо эрсдэлтэй тулгарч байгааг судалгааны үр дүн харуулж байна. Нийт судалгаанд оролцогчдын 6 хувь нь гэр бүлийн гишүүдийн зүгээс сөрөг, заналхийлсэн, дарамтлах хандлага, үйлдэлтэй тулгарч байсан гэж хариулжээ. Энэхүү аюултай байдал нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй бизнес эрхлэгчдийн дунд 2-3 дахин их байна.

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн гуравны нэг нь амар тайван, аюулгүй байдлаа хангах боломжгүй нөхцөлд ганцаараа бизнес эрхэлж байна. Гурван эмэгтэй тутмын нэг буюу 31 хувь нь эмэгтэй хүний хувьд ганцаараа олон нийтийн газар бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд амар тайван, аюулгүй байх боломж хязгаарлагдмал гэсэн хариултыг өгчээ. Нэн ялангуяа, байршлаар нь харьцуулан үзвэл, Улаанбаатар хотод бизнес эрхэлдэг эмэгтэйчүүд илүү өндөр эрсдэлд байгаа нь харагдаж байна. Тухайлбал, худалдаа болон үйлдвэрлэлийн салбарт ажиллаж буй эмэгтэйчүүдийн хувьд орон нутаг хооронд болон улс хооронд зорчихдоо түүхий эдээ татах, байршуулах, борлуулахтай холбоотойгоор орчны хувьд илүү их эрсдэлтэй тулгарч байна.

Зураг 31: Гэр бүлийн гишүүдийн зүгээс заналхийлсэн, дарамтлах сөрөг хандлага, үйлдэлтэй тулгарч байсан байдал



Зураг 32: Ганцаараа (эмэгтэй хүний хувьд) олон нийтийн газар жижиг бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд амар тайван, аюулгүй байх боломж, байршлаар




Зураг 33: Ганцаараа (эмэгтэй хүний хувьд) олон нийтийн газар жижиг бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд амар тайван, аюулгүй байх боломж, хөгжлийн бэрхшээлтэй байдлаар




***Жишээ 21: Бараагаа татахаар ганцаараа Хятад руу явдаг.***

*Би өдийг хүртэл (1995 оноос хойш) коронавирус гарах хүртэл хэзээ ч гэртээ ингэж удаан хугацаагаар байж үзээгүй. Бүтэн сайнд урагшаа яваад 3 дахь өдөр урдаас ирээд шууд зах руугаа шинэ бараагаа зарахаар явна. Буцаад бүтэн сайн өдрөө бараандаа явдаг байсан. Наймаа хийнэ гэдэг бол маш их тэвчээр, туушитай зан, шаргуу байдал шаарддаг.*

*Бизнес эрхлэгч – эмэгтэй –*
*Улаанбаатар хот – худалдаа*

## 4.2 Бизнест үзүүлж буй мэдээ, мэдээллийн үр нөлөө

Чанарын судалгааны үр дүнд эмэгтэй болон эрэгтэй бизнес эрхлэгчдийн аль аль нь төрөөс үзүүлж буй дэмжлэгийн талаар, мөн бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих эх үүсвэр, санхүүгийн болон санхүүгийн бус байгууллагуудын талаар мэдээлэл дутмаг гэсэн нийтлэг хариултыг өгч байна.

**Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн хувьд мэдээлэл хүртээмжгүй бөгөөд мэдээлэл хаанаас авах тухай мэдлэг дутмаг байна.** Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 89 хувь нь бизнесийн дэмжлэг, зөвлөгөөг хаанаас авахаа мэддэггүй гэж хариулсан бол 90 хувь нь салбарын хөгжил чиг хандлагын талаарх сүүлийн үеийн мэдээллийг хаанаас авахаа мэддэггүй гэжээ. Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн дунд гэр бүлийн байдал, бизнесийн салбар болон байршлаас үл хамааран бизнесийн дэмжлэг, зөвлөгөө болон салбарын хөгжил, хандлагын талаар мэдээлэл авахаа мэддэггүй байдал нь нийтлэг байна.

Зураг 34: Бизнесийн дэмжлэг зөвлөгөө авсан байдал




Зураг 35: Салбарын хөгжил, чиг хандлагатай холбоотой мэдээлэл авдаг байдал




**Сургалт болон бизнесийн хөгжлийн үйлчилгээ нь бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн мэдээллийн гол эх сурвалж болж байна.** Судалгаанд оролцогчдоос өнгөрсөн хугацаанд авч байсан санхүүгийн бус дэмжлэгийг тодруулахад гол төлөв оролцогчдын хувьд төрийн байгууллагаас сургалт болон бизнесийн хөгжлийн үйлчилгээг авсан байна. Мөн бичил, жижиг бизнес эрхлэгчдийн хувьд сургалт, зөвлөгөө, менторинг болон бизнес хөгжлийн үйлчилгээ нь санхүүгийн бус гол дэмжлэг болж байгаа нь харагдаж байна. Мөн төрийн байгууллага, олон улсын байгууллагууд (төслүүд) нь жижиг болон бичил (албан бус) бизнес эрхлэгчдийн мэдлэг, ур чадварыг сайжруулж буй гол оролцогч тал болж байгааг судалгааны үр дүнгээс харж болно.

Хүснэгт 6: ЖДҮ-д зориулсан санхүүгийн бус дэмжлэг (хувиар)

| Төрөл | Орон нутгийн эрх бүхий байгууллагууд (аймаг, дүүргийн ЗДТГ гэх мэт) | Банк бус санхүүгийн байгууллагууд | Арилжааны банкууд | МУЗГ-ын байгууллага | Мэргэжлийн холбоод | ТББ | Олон улсын байгууллагууд | ЖДҮ-ийн инкубатор |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Сургалт, Зөвлөгөө, Менторинг | 24 | 4 | 6 | 7 | 13 | 13 | 13 | 10 |
| Бизнес хөгжүүлэх үйлчилгээ | 18 | 6 | 3 | 5 | 11 | 15 | 18 | 15 |

**Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн дунд хувь хүний ур чадвараас илүүтэй бизнестэй холбоотой, захиргааны мэдлэг, ур чадварууд илүү эрэлттэй байна.** Судалгаанд оролцогчдоос өөрсдийнх нь давуу болон сайжруулах шаардлагатай ур чадварынх хариултаас онцлон харвал, эмэгтэй бизнес эрхлэгчдийн хувьд бизнесээ бүртгүүлэх, татвар (НӨАТ) төлөх, төрийн байгууллагатай харилцах, захиргааны холбогдолтой асуудлуудын тухай мэдлэг хомс, сайжруулах шаардлагатай гэж хариулсан нь бизнесээ илүү өргөжүүлэх хүсэлтэй байгааг харуулж байна.

Эмэгтэй бизнес эрхлэгчдийн хувьд өөртөө итгэх итгэл, сэтгэл хөдлөлөө удирдах чадвар, өөртөө анхаарал тавих, ажил-ар гэрийн амьдралаа тэнцвэржүүлэх гэх мэт хувийн ур чадваруудыг өөрсдийн давуу ур чадвар гэж үзэж байна. Харин мэргэжлийн болон бизнестэй холбоотой ур чадваруудыг цаашид сайжруулах шаардлагатай гэжээ. Тухайлбал, гадаад хэл, технологи, зах зээлийн судалгаа, борлуулалтын болон бизнесийн стратеги боловсруулах, зөвшөөрөл авах, түгээлтийн сувгуудаа нэмэгдүүлэх гэх мэт ур чадваруудаа цаашид сайжруулах шаардлагатай гэж үзсэн эмэгтэйчүүдийн хувь өндөр байна.

Хүснэгт 7: Давуу болон сайжруулах шаардлагатай ур чадвар

| Ур чадварууд | Давуу ур чадвар | Сайжруулах ур чадвар |
|---|---|---|
| Өөртөө итгэх итгэл | 82 | 18 |
| Ажил-Амьдралыг тэнцвэржүүлэх | 72 | 28 |
| Сэтгэцийн эрүүл мэнд/стресс менежмент | 64 | 33 |
| Өөртөө анхаарал тавих | 62 | 38 |
| Олон нийттэй харилцах, үг хэлэх | 54 | 44 |
| Өөртөө итгэх итгэл | 51 | 47 |
| Бизнесээ удирдан, зохион байгуулах | 49 | 47 |
| Хүний нөөцөө удирдан, зохион байгуулах  (ажилд авах, сургах, чиглүүлэх) | 46 | 49 |
| Харилцаа холбоо ба танилын сүлжээг өргөжүүлэх | 45 | 54 |
| Нягтлан бодох бүртгэл, тооцоо | 38 | 58 |
| Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн талаар мэдлэг, чадвар (савлагаа, стандарт зэрэг) | 36 | 55 |
| Зах зээлийн судалгаа | 34 | 60 |
| Түгээлтийн сувгууд (Цахим худалдаа г.м) | 34 | 61 |
| Санхүүгийн менежментийн ур чадварууд (хөрөнгө оруулалт хийх, удирдах) | 32 | 64 |
| Борлуулалтын стратеги | 32 | 63 |
| Бизнесийн стратеги, төлөвлөгөө боловсруулах | 31 | 63 |
| Технологийн хэрэглээ (компьютер, цахим сүлжээ ашиглах зэрэг) | 29 | 57 |
| Оюуны өмчтэй холбоотой мэдлэг (лиценз гэх мэт) | 23 | 66 |
| Төрийн байгууллагатай харилцах  (ААН-ийн бүртгэл, НӨАТ, татвар, хураамж зэрэг) | 20 | 62 |
| Бизнесийн Англи хэл | 7 | 86 |

## 4.3 Оролцоо ба бизнес эрхлэлт

**Бизнес эрхлэгч эмэгтэйчүүд өөрсдийн бизнест хамааралтай асуудлаар дуу хоолойгоо илэрхийлж, олон нийт болон улс орны эрх ашигтай холбоотой шийдвэр гаргахад оролцоо муутай, хязгаарлагдмал байна.** Судалгаанд оролцогчдын дийлэнх нь өөрсдийн бизнестэй холбоотой асуудлаар аливаа олон нийтийн эсвэл улсын хэмжээний уулзалтад оролцож байгаагүй байна. Зураг 36, 37-д харуулснаар оролцогчдын зөвхөн 12 хувь нь бизнесээ төлөөлөн үг хэлж, оролцож байжээ. Харин үг хэлж, оролцож байсан эмэгтэйчүүдийн дөнгөж 6 хувь нь шийдвэр гаргалтад нөлөөлж чадсан гэж хариулт өгчээ. Ерөнхийдөө, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн оролцоо хангалтгүй байгаа нь харагдаж байна. "Оролцоо өндөртэй" болон "оролцоо муутай" эмэгтэйчүүдийг хүн ам зүйн болон гэр бүлийн байдлаар нь харьцуулан шинжлэхэд мэдэгдэхүйц ялгаа ажиглагдахгүй байна.

Зураг 36: Оролцох, дуу хоолойгоо илэрхийлэх боломж




Зураг 37: Оролцоо, нөлөө




**Олон нийтийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцоотой эмэгтэйчүүдийн хувьд КОВИД-19 цар тахлын үед гарч буй өөрчлөлтийг эрсдэл багатай даван туулсан байна.** Эмэгтэйчүүдийн оролцоо болон цар тахлыг даван туулж буй байдлыг салбарын үйл ажиллагааны чиглэлээр нь харьцуулан шинжлэхэд орон нутгийн, олон нийтийн, эсвэл улсын хэмжээний чуулган, уулзалтад оролцсон эмэгтэйчүүдийн 37 хувь нь бизнесийн үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа бол, "оролцоогүй, идэвхгүй" эмэгтэйчүүдийн дөнгөж 25 хувь нь хэвийн үйл ажиллагаа явуулж байгаа нь мэдэгдэхүйц ялгааг харуулж байна. Ямар нэгэн үйл ажиллагаанд оролцож байсан эмэгтэйчүүдийн ойролцоогоор 20 хувь нь КОВИД-19 цар тахал бизнесийнх нь үйл ажиллагаанд өөрчлөлт үзүүлээгүй эсвэл бизнес нь өргөжсөн гэж хариулсан бол, эсрэгээрээ "оролцоогүй" эмэгтэйчүүдийн дөнгөж 9 хувь нь л адил хариулт өгчээ. Энэхүү идэвх оролцооны мэдэгдэхүйц ялгаатай байдал нь эмэгтэйчүүд оролцоотой байх тусам бизнесээ тогтвортой авч үлдэх, өөрсдийгөө эрсдэлээс хамгаалах чадамжтай болдгийг харуулж байж болох юм.

Бизнес хөгжлийн үйлчилгээ, хүрээллээ тэлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг төрийн байгууллагуудаас зохиодог бол туршлагаа хуваалцах, хамтын ажиллагаагаа өргөжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг голчлон мэргэжлийн холбоодоос зохион байгуулдаг байна. Оролцогчид санхүүгийн бус дэмжлэг хаанаас авсан тухай Хүснэгт 8- аас харна уу.

Хүснэгт 8: БЖДҮ-д үзүүлж байсан санхүүгийн бус дэмжлэг, хувиар

| | Орон нутгийн эрх бүхий байгууллагууд (аймаг, дүүргийн ЗДТГ гэх мэт) | Банк бус санхүүгийн байгууллагууд | Арилжааны банкууд | МУЗГ/бодлогын түвшинд/ | Мэргэжлийн холбоод | ТББ | Олон улсын байгууллагууд | ЖДҮ-ийн инкубатор | Орон нутгийн эрх бүхий байгууллагууд (аймаг, дүүргийн ЗДТГ гэх мэт) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Сургалт, Зөвлөгөө, Менторинг | 24 | 4 | 6 | 7 | 13 | 13 | 13 | 10 | 9 |
| Бизнес хөгжүүлэх үйлчилгээ | 18 | 6 | 3 | 5 | 11 | 15 | 18 | 15 | 10 |
| Бизнесийн түнш, холбоо сүлжээтэй болох боломжууд | 20 | 5 | 5 | 10 | 10 | 10 | 15 | 15 | 10 |
| Туршлагаа хуваалцах боломжууд | 6 | 0 | 2 | 4 | 29 | 10 | 18 | 10 | 20 |
| Хамтын ажиллагаа, түншлэлийн харилцаа үүсгэх | 10 | 0 | 0 | 3 | 27 | 10 | 17 | 13 | 20 |
| Бодлогын зөвлөгөө, дэмжлэг | 15 | 3 | 0 | 3 | 15 | 12 | 15 | 21 | 15 |
| Сургалт, зөвлөгөө, Менторинг | 2 | 5 | 4 | 6 | 1 | 5 | 3 | 15 | 4 |

**Бизнес эрхлэгч эмэгтэйчүүд, ялангуяа гэр бүлгүй эмэгтэйчүүд санхүүгийн бус дэмжлэг илүү идэвхтэй хүлээж авдаг байна.** Ганц бие өрх толгойлсон 99 эмэгтэйн 20 хувь нь сургалт, зөвлөгөө, менторингийн дэмжлэг авч байсан бол, гэрлэсэн болон хамтран амьдрагчтай 301 эмэгтэйн 10 хувь нь сургалт зөвлөгөө авсан нь ялгаатай байгааг харуулж байна. Чанарын судалгааны үр дүнд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг эрэгтэй бизнес эрхлэгчидтэй харьцуулахад, хүрээллээ тэлэх арга хэмжээ гэхээс илүү сургалтад хамрагдах байдал нь өндөр байна.

Эмэгтэй бизнес эрхлэгчдийн 21 хувь нь холбооны гишүүнчлэлтэй байсан бөгөөд гишүүнчлэлээс үл хамааран аль нэг холбооноос санхүүгийн бус дэмжлэг авч байсан эсэхийг тодруулахад 13 хувь нь мэргэжлийн холбоод, бүлгээс авч хэрэгжүүлсэн сургалт, зөвлөгөө менторинг хөтөлбөрт оролцож, ямар нэг дэмжлэг хүртэж байсан байна. Мөн ихдээ л 4 хүрэхгүй хувь нь бизнес хөгжлийн үйлчилгээ (1.8 хувь), бизнесийн сүлжээ бий болгох (0.5 хувь), туршлага судлах (3.5 хувь), хамтын ажиллагаа байгуулах (2.0 хувь) болон бодлогын чанартай дэмжлэг хүртэж байжээ. Өөрөөр хэлбэл мэргэжлийн холбоодын хүргэж буй туслалцаа дэмжлэг нь гишүүнчлэлтэй бизнес эрхлэгчдэд ч хязгаарлагдмал хүртээмжтэй байна.

**Сургалт зөвлөгөө авсан эмэгтэйчүүдийн 17 хувь нь бизнесийн хэтийн төлөвөө өнгөрсөн жилийнхтэй харьцуулахад “өснө” гэж хариулсан бол, 9 хувь нь “буурна” гэж хариулсан байна.** Хэдийгээр энэхүү хариулт нь хоорондоо хамааралтай гэж дүгнэж болохгүй ч, мэргэжлийн сургалт эсвэл сүлжээнээс явуулдаг дэмжлэг зэрэг нь эмэгтэй бизнес эрхлэгчдийг илүү тэсвэр тэвчээртэй, өөртөө итгэлтэй, шийдэмгий, өөдрөг болгодог байж болно. Эсвэл дээрх шинж чанар нь бүрдсэн бизнес эрхлэгч эмэгтэйчүүд мэргэжлийн түлхүү сургалт, зөвлөгөөнд хамрагдах сонирхолтой байж болно.

Чанарын судалгааны үр дүнгээс харахад бичил (албан бус) бизнес эрхлэгчид ямар нэгэн байгууллагаас зарласан сургалтад суух хандлага илүү байгаа бол нөгөө талд албан бизнес эрхлэгчид илүү шинэ тодорхой чиглэлийн дагуу сургалтыг хайж оролцдог ба зөвлөхүүдтэй холбогдон ажилладаг байна. Сургалтад хамрагдагчид сургалтын ашиг тусыг янз бүрээр хүлээж аван тайлбарласан байна.

**Кейс #3: Арван жилийн дотор өөрийн эсгий, ноосон бүтээгдэхүүний цогц үйлчилгээний төв нээх хүсэлтэй бизнес эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй**

Би ээж, дүү, дүүгийн хүүхдийн хамт дөрвүүлээ Сонгинохайрхан дүүрэгт амьдардаг. Эсгий, ноос ноолуур боловсруулах мэргэжлээр 2009 онд дээд боловсрол эзэмшсэн. Үргэлжлүүлээд 2010 онд УБ их сургуульд Солонгос хэлний орчуулагчаар сурч байгаад тархины усжилт оноштойгоор сургуулиа төгсөж чадаагүй. Тухайн үед цочролд ороод бараг хоёр жилийн турш өвчнөөсөө болоод сурч, ажиллах боломжгүй байсан. Дараа нь өөрөө бүтээгдэхүүнээ хийгээд, борлуулдаг болсон. Өмнө нь манай ээж эсгий, ноосон бүтээгдэхүүн хийдэг байсан юм, тэгээд л гэр бүлээрээ л энэ бизнесээ хийж байна.  2014 оноос хойш би өөрөө борлуулалтаа яг гардаж хийдэг болсон. Одоо бол Улаанбаатарт гол төлөв лангуу, худалдааны төв гээд нийтдээ 9 газар бараагаа өгч зарууладаг.

Өмнө нь ер нь албан бус бизнесүүдэд зориулсан ямар нэгэн төрийн бодлого, арга хэмжээнд хамрагдаж, дэмжлэг авч байгаагүй ч, гэр бүлийн дэмжлэгээр одоо хүртэл бизнесээ эрхэлж байна. Би бүтээгдэхүүнээ гаргах, борлуулах гол ажлаа хариуцаж, дүү маань харин надад тусалдаг юм. Гэхдээ дэмжлэг үзүүлдэг хэдий ч,тэдний зүгээс заримдаа гэр бүл дотор намайг хүнтэй суусангүй, бизнесээ тогтвортой авч явсангүй гэх мэт дарамт, хандлагууд ажиглагдаж л байдаг. Ялангуяа, КОВИД-19 цар тахал гарсны дараа манай борлуулалт огцом унаж, гэр бүлийн зүгээс өдөрт олж буй орлоготой холбоотойгоор гомдоллож эхэлсэн. Гэр бүлийнхэн надтай таагүй харьцахад нь би өөрийн хөгжлийн бэрхшээлдээ илүү их эмзэглэн, хүсэл эрмэлзлээсээ ухармаар, шантармаар санагддаг. КОВИД-19-ын халдварт их санаа зовоож байна, ялангуяа, бизнест маань ихээхэн муугаар нөлөөлөх вий гэдэгт үргэлж санаа зовдог.

Цар тахлын өмнө, би өөр олон төрлийн бүтээгдэхүүн хийх гэж оролдож их үзсэн. Гэхдээ эсгий, ноосон бүтээгдэхүүн хамгийн их борлогддог гол бүтээгдэхүүн байсан. Мөн эсгий оймсыг захиалгаар зөвхөн хийдэг байлаа. Би олон төрлийн бүтээгдэхүүн хийж чадна, гэхдээ илүү зарагдах найдвартай байдлаа бодож эсгий гутал, углааш  л хийдэг. Манай гэр бүлийн хувьд хамгийн авууштай зүйл нь бие биеийнхээ шийдвэрийг хүндэтгэж, бие биеийнхээ хэр их орлого олж байгааг хянаад байдаггүй. Тиймээс, борлуулалтаасаа би бага багаар хуримтлал үүсгэж эхэлсэн. Гэтэл, КОВИД-19 гарч манай гэр бүлийнхэн хадгаламжаараа өдөр тутмын хэрэгцээгээ хангахаас өөр аргагүй байдалд хүрч байна. Бид нар хадгаламжаараа өөрсдийн бараагаа борлуулдаг газартаа жижиг газар худалдан аваад, өөрсдийн бүтээгдэхүүнүүдээ тогтвортой үйлдвэрлэхээр зорьж байсан. КОВИД цар тахлын үед, бид бүтээгдэхүүнээ онлайнаар зарахыг хичээсэн ч, төдийлөн амжилт олоогүй. Одоо бол зөвхөн байнгын үйлчлүүлэгчид маань л бүтээгдэхүүнээ ирж авч байгаа болохоор борлуулалт маш их буурсан байдалтай байна. Үүнээс гадна, одоо бол түүхий эдээ олж, татна гэдэг хамгийн сорилттой асуудал болоод байна. Цар тахал дуусахаар харин өөрийн гэсэн эсгий, ноосон урлалын газраа нээхээр зорьж байна. Яг одоо бол, миний бизнес санхүүгийн асуудал болон түүхий эдийн хомсдолтой холбоотойгоор бүрэн зогссон байдалтай л байна. Миний бодлоор, гэнэтийн иймявдалд зориулсан төлөвлөгөөгүй байсан маань л миний алдаа боллоо гэж бодож байна. Бизнесээ тогтвортой байлгахын тулд уул нь төлөвлөгөөтэй байх ёстой байсан юм.

Нийгмийн амьдралын хувьд  бизнес болон гэр бүлийн хүрээнд л миний амьдрал өрнөдөг болохоор надад ямар нэгэн найз нөхөд, танил ховор байдаг. Зөвхөн үнэнч үйлчлүүлэгчид маань л захиалга өгөхөөрөө залгадаг юм. Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төвөөс авсан тоног төхөөрөмж маань миний бизнестээ авсан хамгийн том хөрөнгө оруулалт болоод байна. Мөн сургалтад суугаад их урам зориг орсон шүү. Өмнө нь хэлсэнчлэн, би бүтээгдэхүүнийхээ дизайн, өнгө сонголт, мөнгө зарцуулалт гээд бүх шийдвэрээ өөрөө гаргадаг. Нэг оёдол хийдэг хүнтэй хамтраад жижиг, дунд бизнесүүдийг дэмжих сангаас зээл авч байсан. Гэхдээ би зээл авахаас аль болох татгалздаг. Зөвлөгөө авах хэн нэгэн байхгүй болохоор өөрөө л энэ бүх шийдвэрээ гаргаж байна даа. Ямартай ч, 10 жилийн дотор өөрийн гэсэн эсгий, ноосон бүтээгдэхүүний цогц үйлчилгээний төв нээх хүсэлтэй байна.

# 5 ДҮГНЭЛТ

## 1. Бизнесийн үйл ажиллагаа ба тогтвортой байдал

**Эмэгтэй эзэнтэй бизнесүүдийн нийлүүлэлтийн сүлжээ нь тасарч, худалдаа/үйлдвэрлэлийн хэмжээ нь буурч, зарим тохиолдолд түр эсвэл бүр мөсөн бизнесээ зогсоох эсвэл ажилчдаа халахад хүрсэн.** Хэдийгээр хөл хорио нь бүхий л салбарт ямар нэг хэмжээгээр нөлөөлсөн ч, салбарын онцлогоосоо шалтгаалан үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарууд хамгийн их хор уршгийг амссан байна. Судалгааны явцад эмэгтэйчүүд түлхүү ажилладаг эдгээр салбарын олон хүн ажлаа алдсан гэж хариулсан. Цагийн ажилчид мөн цар тахлын нөлөөнд өртсөн судалгаа байна. КОВИД-19-ын орон нутгийн зохицуулалтын улмаас хот суурин газарт байгаа эмэгтэйчүүд орон нутагт байгаа эмэгтэйчүүдийг бодвол илүү өртжээ. Мөн гэр бүлгүй эмэгтэйчүүд түлхүү бизнесээ зогсоон хааж байсан нь гэр бүлтэй эмэгтэйчүүдийг бодвол гэр бүлийн зүгээс үзүүлэх дэмжлэг бага байсантай холбоотой байна.

**Зарим цөөн тооны бизнес эрхлэгч эмэгтэйчүүд бизнесээ нөхцөл байдалд дасан зохицуулж, КОВИД-19-ын үед уян хатан арга хэмжээ авсан байна.** КОВИД-19 цар тахлын үеэр эмэгтэй бизнес эрхлэгчдийн 2 хувь нь шинэ бүтээгдэхүүн боловсруулж, үйл ажиллагаандаа шинэ арга барил нэвтрүүлэн дотоодын борлуулалтаа нэмэгдүүлж чадсан байна. Мөн бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн 22 хувь нь хязгаарлалт, хоригийг давахын тулд бизнесээ илүү уян хатан болгож, түгээлт хүргэлтийн аргаа онлайн болгон, үйлдвэрлэлээ гэрээсээ явуулж, эсвэл түүхий эд бэлтгэдэг болжээ. Мөн шинэ эрэлт хэрэгцээг хангах үүднээс бүтээгдэхүүнээ тэр чигээр нь өөрчилсөн зэрэг өөрчлөлтүүд хийжээ. Бүтээгдэхүүн үйлчилгээгээ өөрчлөх төлөвтэй тэн хагас нь ирээдүйн орлогодоо илүү итгэлтэй байсан бол гуравны нэг нь өөрчлөлт хийх төлөвгүй байсан ба ирээдүйдээ итгэлгүй байна.

**Төрийн зүгээс бизнес эрхлэгчдэд үзүүлсэн дэмжлэг нь жижиг болон бичил (албан бус) бизнес эрхлэгчдэд тус дэм болсонгүй.** Цар тахлын үед төрийн зүгээс авч хэрэгжүүлсэн дэмжлэг туслалцаа (татварын хөнгөлөлт, мөнгөн тусламж) жижиг болон бичил (албан бус) бизнес эрхлэгч эмэгтэйчүүд хүртэж чадаагүй гэж дүгнэж болно. Гэхдээ төрийн зүгээс үзүүлсэн цар тахлын нөлөөг бууруулах, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, уур болон халаалтын хэрэглээний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тэглэх арга хэмжээ нь бүх бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд дэмжлэг болсон байна. Энэ арга хэмжээ нь дан бизнес гэхгүй өрх гэр рүү хандсан арга хэмжээ байсан тул, эмэгтэйчүүдэд хүртээмжтэй байсан байна. Мөн бэлэн мөнгө тараасан нь албан бус бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд цар тахлыг даван туулахад нь нэмэр болсон байна.

## 2. Эдийн засгийн капитал

**Бизнесийн үйл ажиллагаа нь доголдоход өрхийн санхүүгийн нөхцөл байдал шууд хамааралтай хүндэрч эхэлсэн байна.** Орлогын хэмжээ буурч, зардал ихсэхийн хэрээр бизнес эрхлэгчдэд зээл, түрээсээ төлөхөд хүндрэл бэрхшээл тулгарсан. Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн өрх гэр тухайн бизнесийн орлогоос ихээхэн хамааралтай байсан байна. Гэр бүлтэй эмэгтэйчүүдийн 70 хувь нь өрхийн орлогын тэн хагасыг олдог, мөн цөөн тооны эмэгтэйчүүд цар тахлын өмнө нөхрөөсөө илүү орлоготой байсан гэж мэдэгджээ. Ерөнхийдөө бизнесийн орлого буурсан нь өрх гэрийн орлогод шууд нөлөөлсөн.

**Санхүүгийн эх үүсвэрийн хүртээмжгүй байдал нь эмэгтэй бизнес эрхлэгчдийн хувьд цар тахлын өмнө ч гэсэн гол хүндрэл бэрхшээлүүдийн нэг байсан байна.** Эмэгтэйчүүд бизнесээ өргөжүүлж, албан болгоё гэхээр барьцаа хөрөнгө, зээлийн өндөр хүүг дийлдэггүй гэсэн байна. Харин эрэгтэй бизнес эрхлэгчдийн хувьд барьцаа хөрөнгө нэг их асуудал болоогүй гэнэ. Судалгаанд оролцогчдын 40 хувь нь бизнесээ эхлүүлэх гэж банк, ББСБ болон бусад газруудаас албан журмаар зээл авсан бол, 56 хувь нь бизнесээ тогтвортой явуулах гэж зээл авсан байна. Дунджаар эмэгтэй бизнес эрхлэгч 2 удаа бизнесийн зээл авсан байна. Дундаж зээлийн хэмжээ 7,307,547 төгрөг, дундаж хугацаа нь 24 сар байна. Гэхдээ бизнес эрхлэгч эмэгтэйчүүд тэтгэврийн зээл, цалингийн зээл зэрэг түлхүү бизнесийн бус зээл авдаг байна. Тухайн зээлийг авахад арай хялбар мөн барьцаа хөрөнгө шаарддаггүй ажээ. Харин их хэмжээний зээл авахад хүндрэлтэй байдаг гэж эмэгтэйчүүд хариулсан байна. Дээрх хүндрэл бэрхшээлүүд хөдөө аж ахуйн салбарт ажилладаг эмэгтэйчүүдээс илүүтэйгээр жижиглэн худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт ажилладаг эмэгтэйчүүдэд тулгарчээ.

**Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн тал буюу 49 хувь нь цар тахлын үеийг даван туулахын тулд өөрийн хадгаламжаа ашиглаж, өөрийн болон бизнесийн эд хөрөнгөө зарсан гэж хариулсан байна.** Харин эрэгтэй бизнес эрхлэгчдийн хувьд санхүүгийн эх үүсвэрийн хүртээмжээс үл хамааран эмэгтэйчүүдийг бодвол хүндрэлийн үед ашиглах бэлэн мөнгөний хадгаламжтай байсан байна. Бизнесээ авч үлдэхэд хэрэгтэй нэн чухал арга хэмжээг дурдахад77 хувь нь санхүүгийн хүртээмж, 40 хувь нь түрээс бууруулах, 39 хувь нь зээлийн уян хатан нөхцөл гэж хариулжээ. Хариултаас харахад хямралаас гарах арга хэмжээ нь техникийн хүчин чадлаас илүү санхүүгийн хүчин чадалд тулгуурлаж байв.

## 3. Нийгмийн болон Бизнесийн хүрээлэл

**Бизнес эрхлэгч эмэгтэйчүүд гэр бүлийн бус хүрээлэл буюу найз нөхөд, хөршүүд, хамт ажилладаг хүмүүсийг их чухал гэж хариулсан.** Харамсалтай нь тэд ямар нэгэн холбоо эсвэл сүлжээнд харьяалагддаггүй. Бизнес эрхлэхэд гэр бүлийн бус хүрээлэл буюу найз нөхөд, хөршүүд, хамтран ажиллагчид их чухал гэж эмэгтэйчүүд үздэг хэдий ч бизнес эрхэлдэг эмэгтэйчүүдийн дийлэнх нь ямар нэгэн олон нийтийн үйл ажиллагаанд хамрагддаггүй, холбоо, бүлэгт элсдэггүй байна.

**Санал асуулгад оролцогчдын 79 хувь нь ямар нэгэн бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн сүлжээ холбоонд харьяалалгүй гэж хариулсан байна.** Нөгөөтэйгүүр, холбоонд харьяалалтай эмэгтэйчүүд ч КОВИД-19 цар тахлын үеэр ямар нэг санхүүгийн болон санхүүгийн бус туслалцаа дэмжлэг аваагүй гэж мэдээлжээ. Үүнтэй харьцуулахад, эрэгтэй бизнес эрхлэгчид санхүүгийн бус тусламжийг багш, мэргэжилтнүүдээс авдаг тул танилын сүлжээгээ тэлэх боломж ихтэй байдаг байна. Харин эмэгтэйчүүд гэр орны үүрэг хариуцлагад илүү их цаг зарцуулдаг тул нийгмийн харилцаанд орох нь бага, нийгмийн капитал хөрөнгө нь хязгаарлагдмал, танилын хүрээллээ тэлэх боломж муутай ажээ.

## 4. Шаардлагатай санхүүгийн бус дэмжлэг

**Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн хэрэгцээнд нийцсэн, тэдэнд зориулсан мэдээллийн хүртээмж дутмаг байна.** Санал асуулгад хамрагдсан эмэгтэйчүүдийн 90 хувь нь салбарынхаа мэдээллийг хэрхэн авахаа мэддэггүй байгаагаас гадна гэр бүлийн байдал, хөгжлийн бэрхшээл, бизнесийн байршил эсвэл салбараасаа үл хамааран, мэргэжлийн болон салбарын мэдлэг мэдээлэл ихээхэн дутмаг байсан. Бизнес эрхлэгчид хүйсээс үл хамааран төрийн зүгээс үзүүлж буй дэмжлэг тусламж, санхүүгийн болон санхүүгийн бус байгууллага, ЖДҮ-ийн дэмжлэгийн талаар мэдээлэл дутмаг хангалтгүй байдаг гэж хариулсан байна. Тоон судалгаанд оролцогчдын 89 хувь нь хаанаас дэмжлэг авахаа мэддэггүй гэжээ.

Албан болон албан бус байгууллагад гишүүнчлэлтэй бизнес эрхлэгчдийн аравны нэг нь санхүүгийн бус дэмжлэг авсан нь цөөн тооны л бизнес эрхлэгчид мэдээлэл олж, тусламж авах боломжтой гэж дүгнэж болно. Туслалцаа дэмжлэг авч чадсан бизнес эрхлэгчдийн дийлэнх нь төрийн байгууллагууд,

Зураг 38: Санхүүгийн бус дэмжлэг авсан байдал, гишүүнчлэлээр




Зураг 39: Санхүүгийн бус дэмжлэг авсан байдал, гэрлэлтийн байдлаар




инкубатор төвүүд, мэргэжлийн холбоо, ТББ болон ОУБ-уудаар дамжуулан авчээ. Үүнээс үзэхэд бизнесийн дэмжлэг авах нь мэдээ мэдээллийн хүртээмжтэй байдалтай шууд холбоотой болох нь харагдаж байна.

**Эмэгтэйчүүд түлхүү бизнесийн холбогдолтой мэдлэг чадвараа дээшлүүлэх сонирхолтой байсан бол цөөн тооны эмэгтэй хувь хүний хөгжлийг сонирхжээ.** Санал асуулгад оролцогчдын 60-аас дээш хувь нь бүртгэл, НӨАТ, татвар г.м төрийн удирдлагатай холбоотой мэдлэгээ дээшлүүлэх, мөн оюуны өмч, бизнесийн стратеги, борлуулалтын стратеги, санхүүгийн менежмент, түгээлт болон зах зээлийн судалгаа хэрхэн хийх талаар сурах сонирхолтой байсан. Харин 86 хувь нь бизнес ур чадвараа сайжруулах сонирхолтой байв. Судалгаанд оролцогчдын 21 хувь нь бизнесийн стратеги боловсруулах, 18 хувь нь  технологийн шинэчлэл нэвтрүүлэх болон 17 хувь нь  нь зах зээлд нэвтрэх зэргийг бизнесээ авч үлдэхэд нэн шаардлагатай арга хэмжээгээр нэрлэжээ.

## 5. Өрх гэр , нийгэм, тогтсон хэв маяг

**Цар тахлын улмаас эмэгтэйчүүдийн цалин, хөлсгүйгээр хийж гүйцэтгэдэг ажил үүрэг нэмэгдсэн.** Хэдийгээр зарим эмэгтэйчүүд гэр бүлийнхэнтэйгээ илүү цаг өнгөрөөх боломжтой болсон гэж хариулсан нь эерэг үр дүн мэт боловч, энэ нь бизнесийн үйл ажиллагаа багасаж орлого буурсантай холбоотой байсан, мөн тэд цалин хөлсгүйгээр хийж гүйцэтгэдэг ажлын ачаалал нь нэмэгдсэн гэж мэдээлсэн. Харин эрчүүдийн хувьд гэр орондоо гүйцэтгэдэг үүрэг роль нь өөрчлөгдөөгүй гэж мэдээлсэн байна. Судалгаагаар гэр орны ажил ихэвчлэн эмэгтэйчүүдийн толгой дээр унадаг, тэд ихэвчлэн нийгэмд тогтсон ойлголт, гэр бүлийн үүрэг хариуцлагын улмаас гэр орныхоо төлөө илүү хариуцлага үүрдэг гэж дүгнэжээ. Цөөн тооны эмэгтэй нь нөхөр болон гэр бүлийн гишүүдээсээ ямар нэг дэмжлэг туслалцаа авсан гэж мэдээлсэн бол, эрэгтэйчүүд гэр бүлийн хариуцлага бизнес явуулахад нь огт саад болдоггүй, ихэвчлэн эхнэртээ найддаг гэж хариулжээ.

Эмэгтэйчүүд өрх бүрд олгосон мөнгөн тэтгэмжийг нэмэртэй байсан гэж үзжээ. Харин сургууль цэцэрлэг хаасан нь гэр орны ажил, хүүхэд харах ажлыг нь нэмэгдүүлсэн гэж хариулжээ. Мөн тэд хүүхдүүдээ харахын хамтаар гэр бүлийн бусад гишүүдээ асрах ажлыг үргэлжлүүлэн хийж байсан. Эмэгтэйчүүдийн хувьд том хүүхдүүд нь биеэ даан, дүү нараа асран, зарим тохиолдолд бараа бүтээгдэхүүн савлаж боохад нь тусалж байсан нь гэр бүлийн зүгээс үзүүлсэн чухал дэмжлэгийн нэг гэж үзжээ.

**Бизнесээ тогтвортой явуулахад бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд гэр бүлийн дэмжлэг нэн чухал байна.** Судалгаанд оролцогч эмэгтэйчүүдийн бизнесийг гэр бүлийн гишүүд нь ихэнхдээ дэмждэг, мөн оролцогчдын 90 хувь нь бие даан шийдвэрээ гаргадаг гэж хариулжээ. Судалгаанд оролцогчдын 5 хувь нь л сөрөг хандлагатай нүүр тулсан гэж хариулжээ. Эмэгтэй, эрэгтэй бизнес эрхлэгчид, гэр бүлийн гишүүд нь өдөр тутмын бизнесийн үйл ажиллагаанд нь бага багаар тус болж

байсан гэжээ. Жишээлбэл үйлчилгээ болон үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулдаг эмэгтэйчүүдийн гэр бүлийн гишүүд үйлдвэрлэлийн дамжлага дээр нь тус болсон гэжээ.

Эмэгтэйчүүд бизнесээ тогтвортой явуулахын тулд гэр бүлдээ хүүхдээ харуулах, гэр орны ажилд туслалцаа авах түлхүү сонирхолтой гэжээ. Чанарын судалгааны үр дүнд, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн хувьд КОВИД-19 цар тахлаас өмнө болон дараа нь гэр бүлийн гишүүдийн зүгээс хүүхэд харах болон гэр орны ажилд нь үзүүлдэг туслалцаа дэмжлэгийн хэмжээд ямар нэг өөрчлөлт гараагүй гэдэг хариуг өгчээ.

**КОВИД-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан бизнесийн орлого багассантай холбоотойгоор зарим эмэгтэйчүүдийн (8 хувь) гэр бүлийн зүгээс сөрөг хандлага, дарамт, заналхийлэл ирсэн байна.** Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн дунд иймэрхүү хандлагыг мэдэгдэх нь 2-3 дахин их байна. Мөн бизнесийн орлого буурах нь гэр бүлийн харилцаанд сөргөөр нөлөөлж байна.

## 6. Нийгмийн амьдрал дахь оролцоо болон шийдвэр гаргалт

Судалгаагаар бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн нийгмийн болон улс үндэсний түвшинд шийдвэр гаргах үйл явц дахь оролцоо сул байгаа харагдсан. Судалгаанд оролцогчдын 10 хувь нь шийдвэр гаргах явцад оролцож байжээ, гэхдээ яг шийдвэр гаргах гэхээс илүүтэйгээр ихэвчлэн мэдээ мэдээлэл олж авах зорилгоор оролцож байжээ. Шийдвэр гаргадаг эмэгтэйчүүд (25 хувь) нийгмийн оролцоо муутай эмэгтэйчүүдээ (9 хувь) бодвол бизнесээ зогсоолгүй, тогтвортой авч явах нь арай илүү байна.

## 7. Аюулгүй байдал

**Судалгаанд оролцогчдын гуравны нэг нь олон нийтийн газар бизнесээ явуулахад аюултай байдаг гэж хариулжээ.** Ялангуяа , Улаанбаатар хотод худалдаа эрхэлдэг мөн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд энэхүү эрсдэлд түлхүү өртдөг гэж мэдээлжээ.





# 6 САНАЛ

Энэхүү бүлэгт капитал хөрөнгө бүхий бизнес, бүртгэлгүй бизнест хямралыг даван туулахад нь дэмжлэг үзүүлэхэд гардаг хүндрэл бэрхшээл, өрх, олон нийт болон нормативын хязгаарлалтыг хэрхэн шийдвэрлэх талаар гарна. Энд мөн нотлох баримт дутмаг хэсгүүдийг онцлон тэмдэглэх болно.

КОВИД-19 цар тахлын үед жижиг болон бичил (албан бус) бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн асуудлууд нь цар тахлын өмнөх үеэс ч улам хүндэрсэн байна. Тэдний хувьд цар тахлаас өмнө шаардлагатай байсан дэмжлэг туслалцаа нь хэзээ хэзээнээс илүү хэрэгтэй болжээ. Цаг алдалгүй бизнесийн үйл ажиллагаанд нь хэрэгцээтэй дэмжлэг туслалцааг үзүүлснээр одоо байгаа бизнесээ өргөжүүлэх, КОВИДын дараа, дахин нээж эсвэл шинэ бизнес эхлэх боломжийг бүрдүүлнэ. Тухайн дэмжлэг туслалцаа нь КОВИД-19-тэй холбоотой стресс, ирээдүйн эрсдэлийг даван туулахад хэрэгтэйгээс гадна, илүү тогтвортой бизнесийн загвар боловсруулан, гэр бүлээ хамгаалахад тус үзүүлэх болно. Монгол Улс дахь эмэгтэй эздтэй жижиг болон бичил (албан бус) бизнесийн талаарх дата мэдээллийг сайжруулах нэн хэрэгтэй. Мөн түүнчлэн өрх толгойлсон эмэгтэйчүүдийн гэр бүл, олон гишүүнтэй өргөтгөсөн өрх, эрэгтэй болон эмэгтэй бизнес эрхлэгчидтэй гэр бүлийн оглолцлын хүчин зүйлс болох нас, байршил, хөгжлийн бэрхшээлтэй эсэх, өрхийн хүн ам зүй зэргийг судлахдаа хүйсээр ангилсан мэдээлэлд онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна.

**Эрсдэлийг даван туулахын тулд эдийн засгийн капитал хөрөнгөтэй болгох замаар бизнесийг дэмжих.** Жижиг болон бичил (албан бус) бизнес эрхэлдэг эмэгтэйчүүдийн санхүүгийн эх үүсвэрийн дутмаг байдал КОВИД-19 цар тахлын үеэр тэдний бизнес илүү хямралд ороход нөлөөлснийг судалгааны үр дүн тодорхой харуулсан. Цар тахлын хүнд үед бизнесээ тогтвортой байлгахад эрэгтэй бизнес эрхлэгчдтэй харьцуулахад бизнес эрхлэгч эмэгтэйчүүд өөрийн санхүүгийн эх үүсвэрээ түлхүү ашигласан байна. Мөн МУЗГ-аас өрх гэр бүлд бэлэн мөнгө тараасан нь тодорхой хэмжээнд эмэгтэйчүүдэд дэмжлэг болжээ. КОВИД-19-ийн үеэр өөрчлөлт хийж, дасан зохицож чадаагүй бизнес эрхлэгчдийг бусад бизнес эрхлэгчидтэй харьцуулахад хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийн талаарх мэдээлэл дутмаг байсан байна. Бичил, жижиг бизнес эрхлэгчдэд зориулсан олон төрлийн хүртээмжтэй санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ, мөн барьцаа хөрөнгөгүй эмэгтэйчүүдэд тохирох санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ боловсруулах нэн шаардлагатай.

Түүнчлэн яаралтай үед ашиглах капитал хөрөнгө болон уян хатан туслалцаа илүү шаардлагатай байна. Бодлогын хэмжээнд БЖДҮ-т тохирох, бизнесийн бус мөнгөн тусламжийн боломжуудыг судлах нэн шаардлагатай. Тухайн тусламж нь бүтцийн асуудлыг хөнгөвчлөн, албан бус салбарт ажилчдад илүү хялбар хүрдэг байх хэрэгтэй.

Өөр нэг саад бэрхшээл нь бизнес эрхлэлт болон бизнес эрхлэхтэй холбоотой жендерийн мэдрэмжтэй хүйсээр ангилсан мэдээлэл байхгүй байгаа нь бодлого боловсруулагчдад эсвэл санхүүгийн байгууллагуудад бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд хэрэгцээтэй дэмжлэг үзүүлэхэд хүндрэл үүсгэж буйг анхаарах хэрэгтэй. Түүнчлэн, Монгол Улсад эмэгтэйчүүдийн өмчит аж ахуйн нэгжийн тодорхойлолт хуульд байдаггүй тул албан ёсны тодорхойлолтыг боловсруулж, холбогдох хууль тогтоомжид тусгаж өгөх нь зүйтэй.

**Бүртгэлгүй бизнес буюу жижиг болон бичил (албан бус) бизнесийн мэдээлэл, мэргэжлийн туслалцааг ялгалгүй үзүүлэх.** Жижиг болон бичил (албан бус) бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн бизнесийг албан бус буюу албан бүртгэлгүй бизнес гэж үзэх хандлагатай байдаг учраас тэдэнд нэн шаардлагатай бизнес хөгжлийн үйлчилгээ, хүрээлэл зэрэг нь хүртээмжгүй байна.

Бизнесээ шинэчилж дасан зохицуулахад санхүүгийн эх үүсвэр, зөөлөн ур чадвар болон бизнесийн мэдээ мэдээлэл, мэргэжлийн сургалт, техникийн дэмжлэг, менторинг зэрэг олон төрлийн дэмжлэг, мэргэжлийн ур чадварууд шаардагдаж байна. Судалгаанд оролцсон бизнес эрхлэгч эмэгтэйчүүд "зөөлөн ур чадвар" эмэгтэй бизнес эрхлэгчдэд чухал чадвар гэдгийг мэдэхгүй байсан нь харамсалтай. Энэ нь бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд тавигддаг ерөнхий шаардлагуудын нэг бөгөөд, үүнийг баталсан олон улсын жишээ туршлагууд их байдаг. Эмэгтэйчүүдийн зөөлөн ур чадваруудыг нэмэгдүүлснээр эмэгтэйчүүдийн өөртөө итгэх байдал, бүтээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээ үзүүлэгч, төрийн байгууллагууд зэрэг зах зээлийн бусад харилцагчидтай харьцахад нь тус болно.

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд бизнесийн хөгжлийн үйлчилгээг хүргэх, санхүүгийн эх үүсвэрийг хүртээмжтэй болгох, шаардлагатай бол бизнесийг албажуулах, мэдээлэл болон дэмжлэг туслалцааны эх үүсвэртэй холбож өгөх, бизнесийн хүрээлэл, инкубатор төвүүдтэй холбох, бизнесийн чиг хандлага, дүрэм журмын талаар мэдээ мэдээлэл олгох нь чухал. Мөн мэдээ мэдээллийг түгээх сувгуудыг судлах, уламжлалт харилцаа холбооны хэрэгсэл болон нийгмийн сүлжээнүүдийг судлах шаардлагатай, энэ нь ялангуяа хөдөө орон нутгийн болон хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд нэн хамааралтай юм.

**Жендерийн хэвшмэл ойлголтын улмаас үүссэн хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх.** Монголын соёл, ёс заншилд гэр орны ажил болон хүүхэд арчлахтай холбоотой үүрэг хариуцлагыг эмэгтэй хүнд оногдуулсан байдаг. Харамсалтай нь тухайн үүрэг хариуцлага нь КОВИД-19 цар тахлын өмнө ч тэнцвэргүй байсан төдийгүй эмэгтэйчүүдэд бизнес эхлүүлэх, ажиллуулах, өргөжүүлэхэд хүндрэл үүсгэдэг. КОВИД-19 цар тахлын улмаас сургууль цэцэрлэгүүд хаагдсан нь эмэгтэйчүүдийн гэр орондоо хэр их ажил хийдгийг ил болгосон. Бизнес эрхлэгч эмэгтэйчүүд бизнес болон гэр орны ажил гээд цалинтай болон цалингүй ажлын давхар ачаалалтай болсон.

Ерөнхийдөө, эмэгтэйчүүдийн энэхүү давхар ачааллыг үнэлж дэмжлэг үзүүлэх хэрэгтэй гэдэг дүгнэлт урган гарч байна. Дэмжлэг нь бэлэн мөнгө олгох , эсвэл ялгаварласан нийгмийн хандлагыг бууруулахад чиглэсэн хэлбэрээр арга хэмжээ байж болно. Мөн түүнчлэн, гэр бүлүүдэд гэр орондоо цалин хөлсгүйгээр хийж гүйцэтгэдэг гэр орны ажил, хүүхэд асрахтай холбоотой ажлыг тэнцвэртэй хуваарилах талаар ярилцан хэлэлцэж болно.

# Хавсралт 1.
# Арга зүй болон гол бүрэлдэхүүн хэсгүүд

2020 оны 10 дугаар сарын 28-ний өдрөөс Хараат бус судалгааны хүрээлэн (IRIM) нь Азийн сан (TAF), Жендерийн Үндэсний Хороотой хамтран Эмэгтэйчүүдийн Эдийн Засгийн Чадавхыг бэхжүүлэх (ЭЭЧБ) төслийн хүрээнд “Монголын бичил болон жижиг бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд КОВИД-19 цар тахлын үзүүлж буй нөлөөллийн үнэлгээ”-г хийсэн.

### Үнэлгээний зорилго

Энэхүү судалгаа нь жижиглэн худалдаа, үйлдвэрлэл (гар урлал, оёдол нэхмэл зэрэг), хөдөө аж ахуйн (орон нутагт) салбарт үйл ажиллагаа явуулдаг бичил, жижиг бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд КОВИД-19 цар тахлын үзүүлж буй нөлөөллийг үнэлэх зорилготой хийгдсэн. Судалгааны хүрээнд эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлтийн мөн чанар, нөхцөл байдал болон тэдний амьдралын бодит байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг авч үзсэн. Түүнчлэн, бүтцийн шинж чанартай хязгаарлалтууд нь эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдэд хэрхэн нөлөөлж байгааг харьцуулан үзэж, цар тахлын эмэгтэй, эрэгтэй бизнес эрхлэгчдэд үзүүлж буй ялгаатай нөлөөллийг мөн судалсан болно.

### Агуулгын хүрээ

Тус судалгааны арга зүй нь Коре Глобал болон Азийн сангийн хамтран боловсруулсан “5С”-ийн үзэл баримтлалын хүрээнд үндэслэн боловсруулагдсан. Энэхүү арга зүй нь иргэдэд хүрч буй капиталын хүртээмж, тэдгээрээс олж авч буй чадамжид нөлөөлж буй хүчин зүйлсэд КОВИД-19 ямар үр нөлөө үзүүлж буйг судлахад чиглэсэн. “Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх” (ЭЭЧБ) төслийн удирдлага, Азийн сангийн зөвлөхүүд, IRIM судалгааны хүрээлэнгийн баг хамтран зөвлөлдсөний дагуу, уг үзэл баримтлалын төсөлд хамгийн их хамааралтай бүрэлдэхүүн хэсгүүд дээр төвлөрч, судалгаагаа хийх шийдвэр гарсан.

Диаграмм 5: Монгол дахь Азийн Сангийн судалгааны хамрах хүрээ



## Үнэлгээний бүрэлдэхүүн хэсгүүд

Үнэлгээ нь хоёр үндсэн бүрэлдэхүүн хэсгээс бүрдсэн ба үүнд Зураг 40-т үзүүлсний дагуу тоон ба чанарын судалгаа багтсан болно.

Зураг 40: Үнэлгээний бүрэлдэхүүн хэсгүүд

| | |
|---|---|
| Бүрэлдэхүүн 1: Тоон судалгаа | • CATI аргыг ашиглан 400 зорилтот оролцогчдоос судалгаа авсан. Тоон судалгаанд зөвхөн эмэгтэй бизнес эрхлэгчдийг хамруулсан. |
| Бүрэлдэхүүн 2: Чанарын судалгаа | • Зорилтот оролцогчидтой 24 Кейс судалгаа болон 48 чиглүүлэгтэй ярилцлага хийсэн. Үүнд эрэгтэй болон эмэгтэй бизнес эрхлэгчдийг хоёуланг нь хамруулсан. |

## Бүрэлдэхүүн 1: Тоон судалгаа

Судалгаанд Улаанбаатар хотын Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт, мөн Увс, Булган, Сэлэнгэ, Дорнод аймагт үйл ажиллагаа явуулж буй жижиг, бичил бизнес эрхлэгчдийг хамруулсан. Мөн судлаачид дараах шалгуурыг хангасан бизнес эрхлэгчдийг сонгон судалгаа авсан. Үүнд:

- 50-аас доош тооны ажилтантай,
- Жижиглэн худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ болон хөдөө аж ахуйн чиглэлд үйлчилгээ явуулдаг,
- Дор хаяж 2 жил үйл ажиллагаа явуулсан,
- 855 сая төгрөгөөс ($ 300,000) доош жилийн дундаж орлоготой.

2020 оны 11 дүгээр сарын 11-ээс 12 дугаар сарын 28-ны хооронд тоон судалгааны мэдээллийг цуглуулсан ба дээрх шалгуурыг хангасан нийт 400 жижиг бизнес болон бичил (албан бус ) бизнес эрхлэгч эмэгтэйчүүд оролцсон. Тоон судалгааны мэдээлэлд Computer Assisted Telephone Interviewing (CATI) буюу компьютерын тусламжтай утсаар ярилцлага хийх аргыг ашигласан ба дунджаар нэг судалгаа 50-60 минут үргэлжилсэн.

Мэдээлэл цуглуулах явцад дараах зүйлсийг бататгаж шалгахын тулд мэдээллийн чанарын хяналтыг мэдээлэл цуглуулах явцтай нэгэн зэрэг зохион байгуулсан:

Мэдээлэл цуглуулах үед мэдээллийн чанарын хяналт нэгэн зэрэг хийгдэж явсан. Үүнд:

- өгөгдлийн бүрэн бүтэн байдал,
- өгөгдлийн найдвартай байдал,
- өгөгдлийн нарийвчлал,
- болон өгөгдлийн тогтвортой байдал.

Судалгааны тоон өгөгдлийг CSPro программ дээр үүсгэн SPSS программыг ашиглан боловсруулсан.

- Тайлбарласан статистик,
- Давтамж болон хөндлөн хүснэгт,
- Таамаглалын сорил авах (chi-square test, t-test etc.) ба
- График судалгаа зэргийг тоон өгөгдлийг шинжлэхэд ашиглав.

Хүснэгт 9-т тоон мэдээлэл цуглуулахад оролцсон оролцогчдын бизнесийн төрөл, байршлыг харуулав.

Хүснэгт 9: Бизнесийн төрөл ба байршил

| | Баянзүрх | Чингэлтэй | Сонгино хайрхан | Увс | Булган | Сэлэнгэ | Дорнод | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Жижиглэн худалдаа | 5 | 15 | 6 | 2 | 23 | 3 | 21 | 75 |
| Үйлдвэрлэл | 34 | 30 | 40 | 36 | 18 | 1 | 18 | 177 |
| Үйлчилгээ | 15 | 2 | 5 | 1 | 12 | 2 | 46 | 46 |
| Хөдөө аж ахуй | 2 | 9 | 5 | 19 | 5 | 52 | 102 | 102 |
| Нийт | 56 | 56 | 56 | 58 | 58 | 58 | 58 | 400 |

400 эмэгтэй бизнес эрхлэгчийн 391 нь бичил бизнес эрхэлж, үлдсэн 9 нь жижиг бизнес эрхэлж байна. Судалгааны шалгуурын дагуу байгууллагын ажилчдын тооноос хамаарч энэхүү үр дүнг гаргасан. Байгууллагын ажилчдын тоог доорх Зураг 39-т харуулав.

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн бизнесийн жилийн орлогын хувьд жилийн дундаж орлого 6.000.000 төгрөг, харин орлогын дээд хэмжээ нь 20 сая төгрөг байв. Орлогыг Зураг 42-т нарийвчлан харуулав.

Зураг 41: Ажилтны тоо




Зураг 42: Жилийн дундаж орлогын хэмжээ



## Бүрэлдэхүүн 2: Чанарын судалгаа

Чанарын судалгааны мэдээлэл цуглуулахад нийт 72 бизнес эрхлэгч оролцсон ба үүний 36 нь эмэгтэй, 36 нь эрэгтэй бизнес эрхлэгчид байсан. Чанарын судалгааны мэдээллийг 2020 оны 12 дугаар сарын 21-ээс 2021 оны 2дугаар сарын 7-ыг хүртэл цуглуулсан.

Хүснэгт 10: Мэдээлэл цуглуулах арга ба оролцогчдын төрөл

| Арга | Тодорхойлолт | Тодорхойлолт |
|---|---|---|
| Чиглүүлэгтэй ярилцлага | • The SSI results facilitated understanding of the r• Чиглүүлэгтэй ярилцлагын үр дүн нь хэлэлцэж буй судалгааны сэдвийг ойлгоход тусалж, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг тодорхойлоход тусалсан.<br>• Чиглүүлэгтэй ярилцлага хийхэд дунджаар 60-90 минутыг зарцуулсан. Чиглүүлэгтэй ярилцлага хийж буй судлаачид ёс зүйн журам, шинжлэх ухааны аргыг чанд мөрдөж ажилласан. Чиглүүлэгтэй ярилцлагуудад дүн шинжилгээ хийх зорилгоор ярилцлагыг бичиг болгож буулгасан. | Бичил, жижиг бизнес эрхэлдэг эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд |
| Кейс судалгаа | • Кейс судалгаанд амьдралын түүхийн ярилцлагын аргыг ашиглан хийсэн. Энэ арга нь хувь хүмүүсийн тодорхой хэв шинжийг тодорхойлох, баримтжуулах эмпирик аргуудын нэг хувилбар бөгөөд бизнес эрхэлдэг эмэгтэйчүүдийн дунд институтийн саадуудаас гадна бусад саад бэрхшээлүүдэд анхаарлаа төвлөрүүлдэг арга юм.<br>• Энэхүү ярилцлагыг хийхэд дунджаар 1-1.5 цаг зарцуулсан. Ярилцлагад дүн шинжилгээ хийх зорилгоор ярилцлагыг бичиг болгож буулгасан. | Бичил, жижиг бизнес эрхэлдэг эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд |

Мэдээлэл цуглуулах хугацаанд нийт 48 чиглүүлэгтэй ярилцлага болон 24 кейс судалгааг зохион байгуулсан. "Grounded theory approach" буюу системчилсэн дүн шинжилгээний аргын дагуу чанарын түүхий өгөгдөлд дүн шинжилгээ хийсэн. Судалгааны асуултууд болон өмнө нь боловсруулсан судалгааны хүрээний дагуу өгөгдөлд дүн шинжилгээ хийх нь тохиромжтой арга байсан. Кейс судалгаа болон чиглүүлэгтэй ярилцлагын тодорхой загварыг гаргахад туслах тодорхой ангиллыг бий болгоод, тус тусад нь кодолсон. Чанарын судалгааны мэдээллийн дүн шинжилгээг дараах алхмуудаар хийсэн:

- o Бүх ярилцлагуудын транскрипци/протокол хийсэн,
- o Транскрипци/протокол бүхий ярилцлагуудыг аналитик хүрээнд (холбогдох судалгааны асуултад) суурилан кодолж, мөн шинээр гарч ирсэн сэдвүүдийг нэгтгэсэн,
- o шинээр гарч ирж буй сэдвүүдэд зориулж кодлогдсон мэдээллийг задалж, цэгцэлж, уншсан,
- o кодыг нэгтгэх замаар сэдвүүдийг тодорхойлсон,
- o давтагдсан өгөгдлүүдээс үүссэн тодорхой хэв маягийг боловсруулсан.

Тайлагнах үйл явцад кейс судалгааг чиглүүлэгтэй ярилцлагын тоон судалгааны ижил үр дүнгүүдтэй нэгтгэсэн.

Хүснэгт 11: Түүврийн хэмжээ, зорилтот байршлаар

| Аргууд | Эмэгтэй | | | Эрэгтэй | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Бичил албан бус | Жижиг албан бус | Албан | Бичил албан бус | Жижиг албан бус | Албан |
| Чиглүүлэгтэй ярилцлага | 8 | 8 | 8 | 8 | 8 | 8 |
| Кейс судалгаа | 4 | 4 | 4 | 4 | 4 | 4 |
| Нийт | 12 | 12 | 12 | 12 | 12 | 12 |

Зураг 43, 44-т чанарын мэдээлэл цуглуулахад оролцсон бизнес эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааны салбар болон байршлыг харуулав.

Зураг 43: Бизнесийн үйл ажиллагааны салбар, n=75




Зураг 44: Оролцогчдын бизнес эрхэлж буй байршил, n=



# Хавсралт 2. Асуумж

## АСУУМЖ

## Нэг. Агуулга

**1. Бизнес эрхлэх болсон шалтгаан/хүсэл эрмэлзэл тань юу вэ? (Холбогдох хариултуудыг сонгоно уу)**

i. Мэдлэг болон ур чадвараа ашиглах хүсэл эрмэлзэл
ii. Гэр бүлийн бизнес
iii. Эдийн засгийн/мөнгөний/ хэрэгцээ шаардлага
iv. Карьер болон гэр бүлийн амьдралаа тэнцвэржүүлэх (гэр бүлээ анхаарах үүрэгтэй холбоотойгоор бүтэн цагийн ажил хийх боломжгүй)
